

# “РЕСУРСПАРТНЕРС ГРУПП” ХХК



## *ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

РД: 5556554

УЛААНБААТАР ХОТ 2025 ОН

## ГАРЧИГ

ГАРЧИГ .....	1
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	1
ОРШИЛ.....	2
I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
III ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	8
IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	9
V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	11
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	11
V.1 СӨРӨГ НӨЛӨӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	12
V.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	13
V.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
V.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
V.5 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	14
V.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
V.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
V.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
V.9 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
V.10 ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
V.11 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ .....	22
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ .....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга.....	3
Хүснэгт 2. Уурхайн солбилцол.....	4
Хүснэгт 3. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал .....	22

## ОРШИЛ

---

“Ресурспартнерс групп” ХХК-ийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөөт ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 23.214 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Үйл ажиллагааны хүрээнд уурхайн бэлтгэл ажлууд, ХАБ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, Батноров сумын ЗДТГ-тай байгуулсан нийгмийн хариуцлагын ажлуудыг хийхээс гадна байгаль орчны болон хүний эрүүл мэндийг хамгаалах, уурхайн бүс нутгийн оршин суугчид руу чиглэсэн нийгмийн сайн сайхны төлөө ажлуудыг хийхээр төлөвлөөд байна.

Уурхайн 2025 онд хэрэгжүүлсэн БОМТ-г боловсруулахад байгаль орчны судалгаа, үнэлгээний мэргэжлийн байгууллага болох “ТӨГРӨГ БАЯН ХАНГАЙ” ХХК-аас мэргэжлийн зөвлөгөө авсан бөгөөд төлөвлөгөөг БОАЖЯ-наас 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар баталсан “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд төлөвлөлтийг тус журмын 1 дугаар хавсралтын “А”-д заасан агуулгаар боловсруулсан болно.

БОМТ-г нийт 5 бүлэг, 13 дэд бүлэгт багтаасан байна.

## “РЕСУРСПАРТНЕРС ГРУПП” ХХК

## I ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

**Төлөвлөгөөний нэр:** “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

**Төсөл хэрэгжүүлэгч байгууллага:** “Ресурспартнерс групп” ХХК

**Төслийн зорилго:** “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ын хүдрийг олборлож, бутлан ангилан, сайн чанарын жоншыг зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

### Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

№	Үзүүлэлтүүд		
1	Аж ахуйн нэгжийн нэр	“Ресурспартнерс групп” ХХК	
2	Улсын бүртгэлийн дугаар	9011328128	
3	Уурхайн нэр	Хавтгай-III	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг	Хэнтий
5		Сум/Дүүрэг	Батноров
6	Ашигт малтмалын төрөл	Хүдэр	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-021578	
8	Ашиглалт эхэлсэн огноо	2024	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот	Улаанбаатар
10		Сум/Дүүрэг	Чингэлтэй
11		Баг/Хороо	6-р хороо
12		Гудамж/Байр	Лааганы гудамж, 63А байр 01 тоот
13	Гар утас	99082810	
14	Захирлын хаяг	Нэр	Гүйцэтгэх захирал Д.Даяндэмэд
15		Гар утас	99082810
16		Электрон шуудан	dalaidayanaa@yahoo.com


**Төслийн байршил:** “Хавтгай -III” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Хэнтий аймаг, Батноров сум,
- Ордын нэр: "Хавтгай-III хайлуур жоншны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Хайлуур жонш
- Трапедийн номенклатур: М-4-139
- Талбайн нийт хэмжээ: 633.58 га



Хүснэгт 2. Уурхайн солбилцол

№	Газарзүйн солбицол					
	Уртраг			Өргөрөг		
1	111	27	1.88	48	5	51
2	111	27	1.88	48	6	51.85
3	111	28	31.87	48	6	51.85
4	111	28	31.87	48	7	51.82
5	111	27	1.88	48	7	51.82
6	111	27	1.88	48	7	1.81
7	111	25	41.87	48	7	1.81
8	111	25	41.87	48	6	36.04
9	111	26	7.18	48	6	35.76
10	111	26	7.18	48	5	51



Зураг 1. Тусгай зөвшөөрлийн талбайн байр зүйн зураг

**Орд ашиглах тусгай зөвшөөрөл:** Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл “Ресурспартнерс групп” ХХК-д 633.58 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож MV-021578 дугаар бүхий гэрчилгээг 2020 оны 04 сарын 21-ний өдөр олгосон байна.

**Уурхайн одоогийн байдал:** “Ресурспартнерс групп” ХХК нь Хавтгай-III хайлуур жоншны ордыг ашиглах ТЭЗҮ-ийг 2024 онд батлуулсан бөгөөд түүнээс хойш үйл ажиллагаа явуулж байна.

**Ил уурхайн эцсийн хүрээ хязгаар, ашиглалтын нөөц:**

Ил уурхайн С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадалсан В' үйлдвэрлэлийн нөөц нь 294.12 мян.тн хүдэр байна. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр  $6.92 \text{ м}^3/\text{м}^3$  буюу  $2.55 \text{ м}^3/\text{тн}$  болж байна.

**Төслийн хүчин чадал:** 2025 оны төлөвлөгөөгөөр бүхэллэг хайлуур жонш экспортод 61.17 мян.тонн гаргана. Орд нь эхний жилд 153 хоног хоёр дахь жилд 275 хоног ажиллана. Уурхайн үйл ажиллагаа нь хоногт 2 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

**Тэсэлгээний ажил:** Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээг **10 хоногт нэг удаа** хийх ба тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу аюулгүй байдлыг дээд зэргээр хангасны үндсэн дээр өрөмдлөг-тэсэлгээний ажлыг мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй компанитай гэрээлэн гүйцэтгүүлнэ.

## II ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Ландшафт:** “Хавтгай-III хайлуур жоншны орд” нь ландшафтын мужлалаар Онон улз голын сав газрын хөмбөн-цулдам нам уул, хотгор, суурьт тал бүхий хээр, хуурай хээрийн мужид багтана. Төслийн талбай орчим нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Хангай-Хэнтийн уулархаг их мужид харьяалагдана.

**Уур амьсгал, агаарын чанар:** Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Өвөлдөө олон жилийн дундаж температур -20 аас, -35°C хэм хүрч, дулаан нь 7-р сард 25 аас 30.9°C хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 200-300 мм тунадас унана, Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 1.8-2 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

**Усан орчин:** Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын сумаар, Эхэнбүрд, Дундбүрд, Адагбүрд, Бургаст зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг.

Ордын сумын талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

**Хөрсөн бүрхэвч:** Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь уулын хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг нимгэн хар шороон хөрс.

**Ургамлан нөмрөг:** Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.

**Амьтан:** Тарвага, бор гөрөөс, цагаан зээр, саарал чоно, үнэг, хярс, шилүүс, мануул, дорго, туулай, чандага, өмхий хүрэн, зурам зэрэг ан гөрөөс элбэг байх ба буга, зэрлэг гахай нилээд байдаг байсан ч ховордсон. Хэрлэн мөрөнд соом, булуу цагаан, зэвгэ, цурхай загас байх ба зарим үед тул загас үзэгддэг.

**Түүх соёлын дурсгалд газрууд:** Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

### Хэнтий аймгийн Батноров сумын нийгэм эдийн засгийн үзүүлэлт:

Засаг захиргааны нэгжийн хувьд сум нь Эрдэнэчандмань, Эхэнбүрд, Баян, Баянбулаг, Идэрмэг, Дундбүрд, Бэрх гэсэн 7 багтай.

2023 оны жилийн эцсийн байдлаар Батноров суманд нийт 5689 хүн ам оршин сууж байна. Үүнээс 2913 нь эрэгтэй, 2776 нь эмэгтэй эзэлж байна. Өөрөөр хэлбэл Батноров сумын нийд иргэдийн 48.8% нь эмэгтэй, 51.2% нь эрэгтэй эзлэж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 1773 өрх бүртгэгдсэнээс 466 өрх буюу 61.3%-ийг 1 ам бүлтэй өрх эзлэж байна. Нийт өрхийн 845 нь малчин өрх байна. Мал сүрэг нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 328.7 мянган толгой мал үүнээс Тэмээ 0.2 мян.толгой, Адуу 32.7 мян.толгой, Үхэр 26.8 мян.толгой, Хонь 175.0 мян.толгой, Ямаа 93.9 мян.толгой мал тус тус тоолуулсан байна. (эх сурвалж: “Хэнтий аймгийн статистикийн эмхэтгэл 2023”, 2024 он)

Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв гэсэн төрийн 6 байгууллагатай. Хувийн хэвшлийн 72 аж ахуй нэгж, иргэн арьс шир боловсруулах, хүнсний дэлгүүр, талх гурилан боовны цех, цагаан идээ боловсруулах, гар урлал, үсчин гоо сайхан зэрэг жижиг дунд үйлдвэрлэлүүд үйл ажиллагаагаа явуулж байна. Томоохон уул уурхай Алтан гадас одонт Бэрхийн уурхай, Ямаатын уурхай, Хавтгайн уурхай, Чимэдийн уурхай, Баяжуулах үйлдвэр гэсэн байгалийн баялаг жонш үйлдвэрлэх, боловсруулах уурхай, үйлдвэрүүдтэй. Эдийн засгийн чадамжийн хувьд Бэрхээс тусдаа төсөвтэй явдаг бөгөөд сумын нийт төсөв нь жилийн 3.2 тэрбум.төгрөг, үүнээс сумын өөрийн татварын орлого 0.2 хувийг нь бүрдүүлэн төвлөрүүлдэг.

### Ш ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

**Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Ил уурхайн аргаар үйл ажиллагаа явуулах учраас газрын гадаргад өөрчлөлт орно. Хөрс хуулалт, гадаад болон дотоод овоолго, бутлах үйлдвэр, ажилтнуудын түр амьдрах байр зэрэг бүхий л уурхайн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид нөлөөлнө.

**Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн шаталтаас үүсэх хорт хий агаар орчныг бохирдуулах, олборлолтын явцад суларсан нарийн ширхэгт тоос агаарт салхиар болон техникийн хөдөлгөөнөөр дэгдэх, бутлуурт орж буй чулуулаг дахь тоос агаарт дэгдэх зэрэг сөрөг нөлөөлөл байна.

**Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл:** Гадаргын болон газрын доорх усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл бага байна.

**Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт, овоолго хийх, дотоод тээвэрлэлтийн явцад ургамлан бүрхэвч устаж дарагдахаар байна.

**Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулалт, олборлолтын үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт, түүнийг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн дуу чимээ, замын тоос зэргээс үүдэн ойр орчимд нутагладаг ан амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах зэрэг сөрөг нөлөөлөлтэй.

Эерэг нөлөөллийн хувьд амьтны аймгийн мониторинг нь энэ бүс нутаг орчмын амьтны хотын тухай шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллээр хангах чухал ач холбогдолтой.

**Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл:** “Ресурспартнерс групп” ХХК–ний ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс, түүнтэй холбоотой эд өлгийн зүйлс илрээгүй байна.

Олборлолтын явцад түүх эд өлгийн олдвор олдсон тохиолдолд холбогдох Төрийн байгууллагад мэдэгдэн хамтран ажиллах шаардлагатай.

**Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл:** Улсад болон орон нутагт тодорхой хэмжээний татвар төлөх, ажлын байр нэмэгдүүлэх, нийслэл хотын барилга зам гүүрийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг түүхий эдээр хангах зэрэг эерэг нөлөөлөл байна.

**Төслөөс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:** Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх магадлалтай.

## IV ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт:** Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

**БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл:** Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

**БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга:** Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах,



шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар БОМТ-ний тайланг боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу хийж гүйцэтгэж байна.



## V ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул эрсдэлийг гаргахгүй байх тал дээр зорилт тавин ажиллаж байна.

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан тушаалтан	албан Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
1	2	3	4	5	6	7	
1.	Дүйцүүлэн хамгаалах ажил хийх	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд тусгасан	захиалга	хүлээлцэх	хүлээлцэх	ХАБЭА	
2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон биелэлт батлуулах	-	захиалга	хүлээлцэх	хүлээлцэх	ХАБЭА	
	Нийт	-					

**V.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах улмаар үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Үйл ажиллагааны үе шатанд	Агаарын чанар	<ul style="list-style-type: none"> <li>Ордыг ил аргаар олборлох үйл ажиллагааны үед тоосжилт бий болох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зам талбай, овоолго, тоос босох гадаргууг усалгаа хийж тоосжилт бууруулах арга хэмжээ авах</li> </ul>	Уурхайн талбайд	1000.0		4сар-10 сар дуустал	-
	Гүний ус	<ul style="list-style-type: none"> <li>Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж урьдчилан сэргийлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Spill kit асгаралтын иж бүрдэл байрлуулах <a href="https://hsct.mn/">https://hsct.mn/</a></li> </ul>	Төслийн хүрээнд	3000.0		6сард	Усны тухай хууль MNS 2662-2002
	Хөрсөн бүрхэвч	<ul style="list-style-type: none"> <li>Техникийн нөхөн сэргээлтийг арга зүйн дагуу хийгээгүй тохиолдолд хөрсөн бүрхэвч доройтох, нөхөн сэргэх чадвараа алдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шимт хөрсний овоолгыг стандартын хадгалах, хамгаалах</li> </ul>	Шимт хөрсний овоолго	500.0		4сар-10 сар дуустал	MNS “5917:2008”
	Ургамлан нөмрөг	<ul style="list-style-type: none"> <li>Уурхайн үйл ажиллагаанаас ургамалан бүрхэвч доройтох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нутгийн унаган ургамлын үр түүх</li> </ul>	Уурхайн талбайд	500.0		9-10сард	MNS 5918:2008

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН  
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөө үүсгэх хүчин зүйл	Байгалийн бүрдэл хэсэг	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх цар хүрээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
		<ul style="list-style-type: none"> <li>ЦДАШ-ыг шувуу мөргөх, тогонд цохиулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шувууны шувууны суулт 2 ширхэг /үүр/ суурилуулах</li> </ul>	Уурхайн талбай орчимд	300.0	600.0	бсард	Амьтны тухай хууль
<b>Нийт</b>						<b>5600.0</b>		

## V.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Тэрбум мод тарих	Орон нутгаас төлөвлөсөн 1 га бүхий газар тарих	ширхэг	100	25000	2500.0	2025 оны 9 сард	-
2.	Биологийн нөхөн сэргээлт-шимт болон биологи хөрс	Шимт хөрсний овоолго хийх	га	-	-	-	4—10сард	MNS 5914: 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
<b>Нийт</b>						<b>2500.0</b>		

### V.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		2	3	4	5	6	7	8
3	Нөхөн сэргээлт аяны хүрээнд орхигдсон эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	1 га бүхий талбайд нөхөн сэргээлт хийх	Орон нутгаас санал болгосон	1га	-	Дотоод төсөв	8-9сард	-
	Нийт					-		

### V.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн ашиглалтын нөлөөллийн бүсэд малчдын хаваржаа болон зуслан, намаржаа байхгүй.

### V.5 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

**V.6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Ажилчдын биеийн эрүүл мэндийн байдалд нөлөөлөх, түүнийг хянах, урьдчилан сэргийлэх	Ажилчдын эрүүл мэндийн үзлэг хамруулах	Ажилчид	-	100.0		Дотоод төсөв бсард	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай 2023-07-07 нэмэлт өөрчлөлт
2.	Гал түймэр гарах	Гал унтраах хэрэгслээр уурхайн кемпийг бүрэн хангах арга хэмжээ авах	Ажилчид	-	10.0	300.0	бсард	Галын аюулгүй байдлын тухай хууль 2015.12.04 нэмэлт шинэчилсэн найруулга
	<b>Нийт</b>					<b>330.0</b>		

**V.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө**

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдлыг хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж хаях, түр хадгалах хог хаягдлын цэгийн газрын гадаргууг цементлэх	Түр хадгалах хатуу ахуйн хатуу хог хаягдлын цэг	-	-	3	630.0	6 сард	Хог хаягдлын тухай шинэчилсэн хууль 2017.05.12
2.	Аюултай	Аюултай хог хаягдал болох ашигласан тос маслыг өөрийн талбайн түр хадгалах цэгт цуглуулах, тусгай зөвшөөрөл бүхий ААН-ээр гэрээ хийж устгуулах	Түр хадгалах аюултай хог хаягдлын цэг	-	-	-	Дотоод төсөв	6 сард	
	Нийт						630.0		

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэрээр нь барилгын болон ажилчдын буюу ахуйн гэж хоёр ангилна. Шинж чанараар нь хатуу, шингэн, хий гэж хувааж болно.

Төслийг хэрэгжүүлэх явцад барилгын ажилчдын түр суурин байгуулах ба үүсэн гарах ахуйн хог хаягдлыг дараах журмаар зохицуулна. Ялгаатай гурван өнгийн хог ангилан цуглуулах савыг барилгын ажилчдын түр сууринд байрлуулна. Доорх хүснэгт үзүүлсэн хаяг болон зааврыг сав бүрд байрлуулна. Эдгээр саванд хогийг зааврын дагуу ангилан хийж байгаа эсэхэд тухайн төслийн байгаль орчин эсвэл эрүүл ахуйн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана.

	<p>Өнгийн шил, гэрлийн шил, толь, цонхны болон бусад шил хийхийг хориглоно!!!!</p>
	<p>Цаас болон бусад сонин сэтгүүл, цаасан хайрцаг, уут гэх мэт цаасан бүтээгдэхүүн, ус үл нэвтрүүлэх хайрцгууд. Эдгээрийг хогийн саванд хийхийн өмнө хавтгайлж нугалж хийнэ!!!</p>
	<p>Төмөр, хуванцар сав, баглаа боодол болон хуванцар сав хийнэ. Резин болон гялгар эдийг хийхгүй!!!</p>

Зураг 1. Хогийн савны төрөл

**Хогийн саванд тавигдах шаардлага: (Хог хаягдлын тухай хууль)**

15.1.1. хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

15.1.2. галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

15.1.3. хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн.

**Хог хаягдал түүнийг цэвэрлэх, зайлуулах болон зохицуулах хэлбэр:**

- Хог хаягдлыг орон нутгийн нэгдсэн хогийн цэгт нийлүүлэх талаар гэрээ байгуулж, холбогдох татвар хураамжийг цаг хугацаанд төлөх
- Ангилсан хог хаягдлаас боломжтой хэсгийг хоёрдогч түүхий эдийн цэгүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тогтмол тушаана.



- Барилгын ажлыг гүйцэтгэх явцад гарах хатуу хог хаягдлыг мөн түр цуглуулах цэгийг байгуулж хамгаалалтын хашаа, бункерт хийнэ. Ингэхдээ хууль, журмын дагуу энгийн, хяналттай, аюултай шинж чанараар нь ангилж хадгална. **Үүнийг хог хаягдал тээвэрлэх, устгах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр тушааж байна.** Төслийн хог хаягдал хариуцсан мэргэжилтэн хог хаягдлыг тушаасан талаарх тэмдэглэлийг тогтмол бүртгэнэ.
- Шатах тослох материалын сав, ахуйн цэвэрлэгээ, ариутгалын бодисын сав, баглаа боодлыг мөн тусад нь цуглуулна.
- Шингэн хаягдал болон бохирын асуудлыг Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын дагуу бохирыг соруулж зөөвөрлөх боломжтой байхаар зохион байгуулах
- Бохирыг соруулах, зөөвөрлөх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах.

## V.8 Орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө

	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (урьдчилсан мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
	<p>Агаарын чанар:</p> <p>Агаарын тоосжилтын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх</p> <p>Агаарын бохирдлын (NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх. БОШТЛ-ын багажаар.</p> <p>Дуу чимээ хянуулах</p>	<p>Төслийн талбайн авто зогсоол,</p> <p>Ухашны салхин доод талд</p>	<p>Тоосны хяналт: Төслийн талбайд 2 цэгт</p> <p>1 удаадаа Өдөрт 2 удаа</p> <p>Жил бүрийн 9 сард</p>	1200.0	<p>MNS 4585-2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага,</p> <p>MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага,</p> <p>MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга</p> <p>MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга,</p> <p>MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга,</p> <p>MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга</p>

*ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ХАВТГАЙ Ш ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРД”-ЫН  
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*

	<p>Усны хяналт шинжилгээ: Унд ахуйн усны ерөнхий хими үзүүлэх</p>	<p>Худаг: Унд ахуйн усыг хангаж буй гүний худгаас</p>	<p>Жил бүрийн 9 сард</p>	<p align="center">234.5</p>	<p>MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт</p>
	<p>Хөрсний төлөв байдал, бохирдол: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO<sub>3</sub>, P<sub>2</sub>O<sub>5</sub>, K<sub>2</sub>O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр</p>	<p>Төслийн талбайн хог хаягдлын цэг болон ариун цэврийн байгууламжийн цэгт хөрсний эрүүл ахуйн бактерийн холимог дээж авах  ШТС болон автомашин зогсоол хөрсний агрохими болон хүнд металлын дээж</p>	<p>Төслийн үйл ажиллагаа дуусахаас өмнө 1 удаа,  Жил бүрийн 9 сард</p>	<p align="center">1000.0</p>	<p>MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга</p>
<p>Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын тухайн жилийн нийт зардлын дүн</p>				<p align="center">2,434.5</p>	

**V.9 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв Мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 08	Сар 09	Сар 10		
1	2	3	4	5	6	7	
1.	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах	1500.0	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	ХАБЭА	АБОГ, БОУАӨЯ
2	Энгийн хог хаягдлын гэрээ сунгуулах	-	захиалга	Явцтай танилцах	хүлээлцэх	ХАБЭА	Сумын Хот тохижуулах газар
	Нийт	1500.0					

**V.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

№	БОМТ, хэрэгжилтийг оролцогч талууд	БОМТ-ний тайлагнахад хэлбэр	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах тушаалтан/ажилтан албан	Зохион байгуулах газар
	1		2	3	4	5	6	7
1.	2025 оны БОМТ-ны дагуу танилцуулах	Төлөвлөгөөг	Цаасан, цахимаар	Тухайн онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө	2025.02 сард	-	ХАБЭА	АБОГ, БОУАӨЯ
3.	2025 оны БОМТ-ны дагуу хэрэгжилтийг тайлагнах	БОМТ-ны дагуу тайлагнах	Цаасан, цахимаар зургаар	Тухайн онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах	2025.11 сард	-	ХАБЭА	АБОГ, БОУАӨЯ
	Нийт					-		

**V.11 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

Хүснэгт 3. Тухайн жилийн БОМТ-ний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,600,000.0
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10,290,000.0
3	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,500,000.0
4	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	300,000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	630,000.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,394,000.0
7	БОМТ-г хэрэгжүүлэх тухайн жилийн удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,500,000.0
8	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардал
<b>Нийт</b>		<b>23,254,500.0</b>

“Ресурспартнерс групп” ХХК-ний Хавтгай-III хайлуур жоншны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 онд нийт 23.214 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

### АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
6. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2024 он
7. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах ТЭЗҮ 2024 он
8. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
9. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III хайлуур жоншны орд”-ыг ашиглах 2024 оны батлагдсан уулын ажлын төлөвлөгөө
10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
11. <http://www.legalinfo.mn>

Хүсэлтийн лавлах дугаар: 321918215

Татсан огноо: 2025-02-26 14:26

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
1905010491 MN350015001905010491	100900013406	5,625,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр РЕСУРСПАРТНЕРС ГРУПП	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний утга MV-021578 Ресурспартнерс групп ХХК рд:5556554 БО нөхөн сэр Гүйлгээний огноо 2025-02-26	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Д. ДОРЖДАЛАЙ		



Хүсэлтийн лавлах дугаар: 327669919

Татсан огноо: 2025-03-26 11:39

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
1905010491 MN350015001905010491	100900013406	6,002,250.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр РЕСУРСПАРТНЕРС ГРУПП	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний утга MV-021578 Ресурспартнерс групп ХХК рд:5556554 БО нөхөн сэр Гүйлгээний огноо 2025-03-26	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Д. ДОРЖДАЛАЙ		

Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: "Ресурспартнерс групп" ХХК - ны 2024 оны БОМТөлөвлөгөөний биелэлт
2. Төслийн байршил: Хэнтий аймаг Батноров сум
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021578
4. Огноо: 2024.12.27.

№	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо								Гишүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар
			Б.Амгаланбат	Г.Мөнх-Эрдэнэ	Ц.Батбуян	Г.Отгонбаяр	Б.Өсөхбаяр	Ж.Ариунбаяр	Э.Зулцэцэг			
	1	2	3	4	5	6	7	8	9	10	13	14
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	16	16	16	16	16	16	16		16	10 ажил төлөвлөсөн 8 ажил гүйцэтгэсэн
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	-	-	-	-	-	-	-		30	Нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй.
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10		10	2 ажил төлөвлөсөн 2 ажил гүйцэтгэсэн.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-		5	Ажил төлөвлөөгүй

5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	1 ажил төлөвлөсөн 1 ажил гүйцэтгэсэн.
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.5	7.5	4 ажил төлөвлөсөн 3 ажил гүйцэтгэсэн.
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	3 ажил төлөвлөсөн 3 ажил гүйцэтгэсэн.
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	3.3	3.3	3.3	3.3	3.3	3.3	3.3	3.3	3.3	Дуу чимээнд хэмжилт хийгдэхээр төлөвлөсөн. Хэмжилт хийгдээгүй. Хөрсний шинжилгээг 4 цэгээс 1 удаа хийхээс 4 цэгээс 1 удаа хийгдсэн. Усны шинжилгээг 1 цэгээс 1 удаа хийхээр төлөвлөснөөс шинжилгээ хийгдсэн.
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	4	4	4	4	4	4	4	4	4	5 ажил төлөвлөсөн 4 ажил гүйцэтгэсэн.
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5	5	3 ажил төлөвлөсөн 3 ажил хийгдсэн
	Нийт оноо	100	90.8	90.8	90.8	90.8	90.8	90.8	90.8	90.8	90.8	Биелэлт хангагдсан.

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээс нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгдөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Нийт гишүүдийн олонхын саналаар Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт 90.8%-тай дүгнэгдсэн, 2025 оны БОМТ-г БОАЖСайдын 2019 оны А/618 тушаалаар батлагдсан журмын дагуу боловсруулж батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах.

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга  
/ Б.Амгаланбат /

Гишүүд:

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч  
/ Ц.Батбуян /

БОАЖГ-ын Газар, газрын хэвлий түүний байлагийн ашиглалт, уул уурхай,  
БОНБҮнэлгээ хариуцсан мэргэжилтэн / Г.Мөнх-Эрдэнэ /

Тухайн сумын Засаг дарга / Г.Отгонбаяр /

Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч / Б.Өсөхбаяр /

Тухайн сумын Байгаль хамгаалагч / Ж.Ариунбаяр /

Тухайн сумын Газрын даамал / Э.Зулцэцэг /

Хүлээн зөвшөөрсөн:

“Ресурспартнерс групп” ХХК –ны менежер / Х.Сүхбат /






БАТЛАВ:

"РЕСУРС ПАРТНЕРС ГРУПП" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д. ДАЯНДЭМЭД

Resource Partners Group  
УЛААНБААТАР ХОТ

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА: М.МЭНДБАЯР



## ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН НУТАГТ ОРШИХ ХАВТГАЙ-III ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

(Жилийн хүчин чадал 193.0 мян.тн хүдэр)

Тусгай зөвшөөрлийн талбайн дугаар: MV-021578

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН

САЛБАР ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *B. Хулан* Б.ХУЛАН

ШИНЖЭЭЧ:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР



*J. Жаргалсайхан* Х.ЖАРГАЛСАЙХАН

ЗӨВЛӨСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР



*J. Жаргалсайхан* Л.ЖАРГАЛСАЙХАН

ТОСОЛ БОЛОВСРУУЛАГЧ

УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСЛИЙН "ЦАРИН-РЕСУРС" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕР

ТӨЛӨВЛӨЛТИЙН ИНЖЕНЕР

БАЯЖУУЛАГЧ ИНЖЕНЕР

ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСАГЧ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН



*B. Буянхишиг* Б.БУЯНХИШИГ

*P. Насанжаргал* П.НАСАНЖАРГАЛ

*A. Жавхлан* А.ЖАВХЛАН

*Ч. Доржготов* Ч.ДОРЖГОТОВ

*Ж. Номин-Эрдэнэ* Ж.НОМИН-ЭРДЭНЭ

*Г. Мөнхзул* Г.МӨНХЗУЛ



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 07 сарын 16 өдөр

Дугаар Т/112

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл  
бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Т/24-17-05 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Ресурс партнерс групп ХХК-ийн MV-021578 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг бүртгэсүгэй.

2. Бүртгэсэн техник, эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

5. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Ресурс партнерс групп ХХК-ийн MV-021578 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хуулсан дискийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хүлээн авахыг Уул уурхайн хэлтэс (Т.Зууннаст)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

*Handwritten signature*

Л.БАЯРМАНДАЛ

1524100726





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 05

Дугаар 7/24-17-05

Улаанбаатар хот

*Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай*

Ресурс партнерс групп ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн Цариг ресурс ХХК боловсруулсан Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Монгол улсын зөвлөх инженер Х.Жаргалсайхан шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник, эдийн засгийн үндэслэл нь уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүх шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник, эдийн засгийн үндэслэл нь Төслийн гол үзүүлэлтүүд, Ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Олборлолт, Үйлдвэрлэлийн процессуудын технологи, зохион байгуулалт, Баяжуулах хэсэг, Хүний нөөц, Дэд бүтэц, барилга байгууламж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Уурхайн санхүү, эдийн засаг зэрэг 10 бүлэг, Дүгнэлт, Ашигласан материал бүхий 201 хуудас тайлбар бичиг, 12 хавсралт зургаас бүрдэж байна.
4. Хавтгай III хайлуур жоншны ордын MV-021578 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын ХХ-17-08 тоот дүгнэлт, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Н/133 тоот тушаалаар 41.86%-ийн агуулга



бүхий боломжтой (С) зэрэглэлийн 293.58 мян.тн хүдрийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ил уурхайн хаягдлыг 2.42% буюу 7.03 мян.тн хүдэр, бохирдлыг 3.63% буюу 10.55 мян.тн байхаар тооцож геологийн боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцсоноор 294.12 мян.тн хүдэр олборлохоор тооцжээ. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 752.34 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 193.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 2 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар гадаад овоолготой, авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд ECD45E маркийн өрмийн машин 1, CAT D6 маркийн бульдозер 1, Hyundai R500 LC7 маркийн экскаватор 2, XCMG XGA5902D3T маркийн автосамосвал 3, SEM маркийн утгуурт ачигч 1, Dongfeng маркийн усны машин 1, Dongfeng маркийн түлшний машин 1, баяжуулах хэсэгт PE 600x900 маркийн хацарт бутлуур 1, 2YK1237 маркийн чичиргээт шигшүүр 1 зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Баяжуулах хэсгийн технологийг Геологийн төв лаборатори ТӨҮГ-т хийгдсэн шинжилгээнд тулгуурлан Эпсилонмет ХХК-ийн хийж гүйцэтгэсэн технологи туршилтын тайлан болон захиалагч талаас өгсөн техникийн даалгаварт үндэслэн сонгосон байна. Баяжуулах хэсгийн хүчин чадал 193.0 мян.тн/жил байна.

9. Уурхайгаас олборлосон 40.35%-ийн дундаж агуулга бүхий 294.12 мян.тн хүдрийг буталж, шигшин бүхэллэгээр ангилсны дараа гар аргаар ялган ФК-85 маркийн баяжмал 73.53 мян.тн, бага агуулгатай буюу 25.46%-ийн агуулгатай хүдэр 220.59 мян.тн-ыг гаргахаар тооцжээ.

10. Хавтгай III хайлуур жоншны уурхайн жилийн цахилгааны хэрэглээ 526,122.68 кВт бөгөөд хэрэглэгчдийг дизель генератораар цахилгаан эрчим хүчээр хангахаар тооцжээ. Төслийн хугацаанд нийт 6.57 мян.м<sup>3</sup> ус шаардлагатай бөгөөд үүнээс ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 2.88 мян.м<sup>3</sup> ус, зам усалгаанд 1.39 мян.м<sup>3</sup> ус, нөхөн сэргээлтийн усалгаанд 2.29 мян.м<sup>3</sup> ус ашиглахаар тооцжээ. Ордын шаардлагатай унд-ахуйн болон технологийн усны хэрэгцээг тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдөж гаргасан гүний худгаас хангахаар тусгажээ.

11. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 2,470.69 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 74.80 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлт болон овоолго хэвгийжүүлэх зардалд 1,183.45 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 285.11 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 883.17 сая төгрөг, хаалтын дараах хяналтын зардалд 44.16 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

12. Уг төслийг хэрэгжүүлснээр 108 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 3.36 сая төгрөг байхаар байна.

13. Хавтгай III хайлуур жоншны ордыг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 6,905.84 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 340.0 сая төгрөг, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 4,515.0 сая төгрөг, тавилга эд хогшилд 390.0 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 910.0 сая төгрөг, биет бус хөрөнгө оруулалт 750.84 сая төгрөг



байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал ашиглалтын хугацаанд 3,735.84 сая төгрөг байхаар тооцоолжээ.

14. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 51,793.85 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 70,057.54 сая төгрөгийн борлуулалт хийж, 18,463.69 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 15,528.58 сая төгрөгийн цэвэр ашигтай, 16,438.58 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 17,501.28 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 тн хүдрийн бүрэн өөрийн өртөг 176,096 төгрөг байна.

15. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 19,264.42 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @15%) 10,824 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 107%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.0 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник, эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна. Үүнд:

1. Төсөл захиалагч Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, хэрэгжүүлэн ажиллах;
2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах;
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
4. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн Цариг ресурс ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол улсын зөвлөх инженер Х.Жаргалсайхан тус тус хариуцах.

Техник, эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг бүртгэн авах;
2. Техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник, эдийн засгийн үндэслэлд дахин тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;

3. Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хавтгай III хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах техник, эдийн засгийн үндэслэл, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн ажлын 5 өдөрт багтаан хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.МЭНДБАЯР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.ГАН-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.Хулан

Б.ХУЛАН



Ашигт малтмал, газрын тосны газрын даргын  
2022 оны 12 дугаар сарын ..... -ны өдрийн  
..... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

**Батлав:**

Ресурс партнерс групп ХХК-ийн  
захирагч ..... Д. Даяндэмэд /



**Хүлээн авсан:**


АМГТГ-ын Уул уурхайн хэлтсийн  
дарга ..... Зууннаст /



## ХЭНТИЙ АЙМГИЙН БАТНОРОВ СУМЫН ХАВТГАЙ-III ОРДЫН 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



Ашигт малтмалын төрөл: Хайлууур жонш  
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-021578  
Нэмэлт АТЗ-ийн дугаар:



Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

/П.Зоригт/

**БОЛОВСРУУЛСАН:**

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч

1.4  
.....  
.....  
.....  
.....  
.....

2025 он

## Гарчиг

<b>ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....</b>	<b>3</b>
<b>1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....4</b>	<b>4</b>
1.1 Төслийн зорилго .....	4
1.2 Ордын байршил.....	4
<b>2. ОРДЫН ГЕОЛОГИЙН НӨӨЦ .....</b>	<b>5</b>
2.1 Нөөц тооцсон үндсэн зарчим ба үндэслэл .....	5
2.2 Нөөцийн тооцооны үр дүн.....	6
<b>3. УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ .....</b>	<b>7</b>
3.1 Ашиглалтын систем .....	7
3.2 Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо .....	8
3.3 Уурхайн жилийн хүчин чадал .....	9
3.4 Уурхайн ажиллах горим .....	9
3.5 Хүдэр олборлолтын ажлын календарь төлөвлөлт .....	10
3.6 ил уурхайн технологийн үндсэн процессууд .....	11
<b>4. ХҮДЭР АНГИЛАН ЯЛГАЛТ .....</b>	<b>12</b>
4.1 Баяжуулах технологийн шийдэл.....	12
4.2 Баяжуулах технологийн схем.....	13
4.3 Бүтээгдэхүүн гаргалтын төлөвлөгөө.....	14
<b>5. ДЭД БҮТЭЦ БА УДИРДЛАГА .....</b>	<b>15</b>
5.1. Цахилгаан тэжээгүүрийн сонголт, тооцоо.....	15
<b>6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ .....</b>	<b>17</b>
6.1 Уурхайн аюулгүй ажиллагаа.....	17
6.2. Ил уурхайн – хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй.....	18
6.3. Уулын үйлдвэрийн аюулгүй ажиллагаа .....	20
Уул уурхайн машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагаа .....	20
6.4. БАЯЖУУЛАХ ХЭСГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА .....	25
6.5. Тэсэлгээний ажлын үед баримтлах хөдөлмөр хамгаалал .....	27
<b>7. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ .....</b>	<b>28</b>
7.1. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ.....	28
7.1.1. Байгаль орчныг хамгаалах ажлын удирдлага ба хяналтын систем.....	28
7.2. Хууль эрх зүйн орчин .....	30
7.2.1. Тусгай зөвшөөрлийн төлбөр.....	30
<b>7.2.2. Газрын хэвлийг ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах журам .....</b>	<b>30</b>
7.3. Уурхайн нөхөн сэргээлт, төслийн хаалт .....	32
7.4. Уурхайн хаалтын горимын төлөвлөгөө.....	34
7.4.1 Уурхайг түр хугацаагаар хаах хаалтын төлөвлөгөө .....	34
7.4.2. Уурхайг тодорхойгүй хугацаагаар хаах хаалтын төлөвлөгөө .....	35
7.4.3 Уурхайг эцсийн байдлаар хаах хаалтын төлөвлөгөө .....	35
7.4.4. Хаалт, нөхөн сэргээлтийн ажлын зорилго, шаардлага.....	36
7.4.5. Уурхайн хаалтын төлөвлөлт .....	37
8.1 Нийт зардлын задаргаа (14-р маягт) .....	38

8.2 УЛС ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОРУУЛАХ ОРЛОГО (15-Р МАЯГТ).....	38
8.3 ЭДИЙН ЗАСГИЙН ХЭСЭГ (16-Р МАЯГТ).....	39
8.4 Борлуулалтын орлого .....	39

### ТӨСЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Утга
<b>А. ОРДЫН НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>			
1	Ордын геологийн нөөц	мян.тн	293.598
2	Ордын үйлвэрлэлийн нөөц	мян.тн	294.12
3	Жилийн хүчин чадал	мян.тн	193
4	Ордын ашиглалтын хугацаа	жил	2
<b>Б.УУРХАЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>			
1	Ашиглалтын систем	-	Ил аргаар гадаад овоолгогой, автотээвэртэй ашиглалтын систем
<b>Ил уурхай</b>			
1	Доголын өндөр	м	5
2	Ажлын бус доголын өндөр	м	10
3	Уурхайн хажуугийн өнцөг	град	45
4	Аюулгүйн бермийн өргөн	м	4.5
5	Доголын хажуугийн өнцөг	град	60
6	Автозамын өргөн	м	15
7	Замын налуу	%	80
8	Ажлын талбайн өргөн	м	37.5
9	Траншейны налуу	%	80
<b>В. АНГИЛАН ЯЛГАХ ХЭСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>			
1	Хүдэр	мян.тн	244.69
1.1	Агуулга	%	40.82
1.2	Баяжмалын хэмжээ	мян.тн	61.17
2	Бага агуулгатай хүдэр	мян.тн	183.51
2.1	Агуулга	%	25.13
<b>Г. ТЕХНИК-ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>			
1	Экскаватор Hyundai R500 LC 7	ш	2
2	Автосамосвал XCMG XGA5902D3T	ш	3
3	Утгуурт ачигч SEM	ш	1
4	Өрмийн машин ECD45E	ш	1
5	Анхан шатны хацарт бутлуур PE600*900	ш	1
6	Чичиргээт шигшүүр 2YK1237	ш	1
7	Тоос барих төхөөрөмж YTXF-280	ш	1
8	Конвейер B1200x10m	ш	3
9	Конвейер B1200x30m	ш	1
10	Гар ялгалт хийх конвейер	ш	1
11	Бункер	ш	1

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


### 1.1 Төслийн зорилго

“Ресурс Партнерс Групп” ХХК нь Хэнтий аймгийн Батноров сумын нутагт орших “Хавтгай-III” нэртэй хайлуур жоншны ордын нөөц нь тогтоогдож батлагдсан ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, ашиглалтын үйл ажиллагааны явцад байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, нөөцийг хаягдал багатайгаар бүрэн ашиглах, техник тоног төхөөрөмжийн харилцан хамаарал зохицолдлогоог хангаж ашиглалтын зардлыг бага байлгах, эрүүл аюулгүй үйл ажиллагааг явуулахад энэхүү төслийн зорилго оршино.

### 1.2 Ордын байршил

Хавтгай-III хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Батноров сумын нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Хэнтий аймаг, Батноров сум
- Ордын нэр: Хавтгай-III хайлуур жоншны орд
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Хайлуур жонш
- Талбайн планшит: М-49-139-Г
- Талбайн нийт хэмжээ: 633.58 га



Ордын байршилын тойм зураг



## 2. ОРДЫН ГЕОЛОГИЙН НӨӨЦ

Хавтгай-III хайлуур жоншны орд нь Дорнод монголын атираат системийн Хэрлэнгийн структур-тектоникийн бүсийн хүрээнд багтдаг бөгөөд Хойд Хэрлэнгийн металлогенийн муж, Бэрх-Түмэнцогтын хүдрийн зангилааны нэгээхэн хэсэгт оршино.

Хайлуур жоншны ордыг 1978 онд Б.Ходиев нар эрлийн ажлаар нээн илрүүлсэн гэж үздэг. Эрлийн ажлаар 50-70 м зайтай суваг малталтын ажлыг гүйцэтгэж  $C_2$  зэрэглэлээр үнэлгээ өгсөн байна. 1980-1981 онуудад Бэрхийн уурхайнхан ил уурхайн олборлолт хийж байгаад зогсоосон байна.

Ордын хэмжээнд палеозойн Хэрлэнгийн бүрдлийн боржин, мезозойн настай дэл судлын чулуулаг, дөрөвдөгчийн хурдас тархана.

**Палеозойн Хэрлэнгийн бүрдлийн боржин** нь ордын хэмжээнд зонхилон тархах ба Хэрлэнгийн бүрдлийн 2-р фазид дунд ширхэгт боржин, дунд-том ширхэгт лейкоборжин, порфирлог боржин багтдаг байна. Боржингийн бүрдэл нь хүдрийн биетийн хил заагаар хүчтэй каолинжих, бага зэрэг серицитжих, лимонитжих хувиралд орсон байна.

**Мезозойн дэл судлын чулуулгууд** нь ногоон саарал, саарал өнгийн, жижиг дунд ширхэгт диорит порфир байх ба каолинжих, хлоритжих, карбонатжих хувиралд орсон байхаас гадна хүчтэй төмөржилт явагдсан байдаг.

**Дөрөвдөгчийн хурдас** ордын хэмжээнд элюви-дельюви байдлаар бүрхэх ба хурдсын зузаан 0.5-3.0 м байна.

Хавтгай-III хайлуур жоншны орд нь 3 хүдрийн биетээс тогтох ба уг хүдрийн биетүүд нь бие биедээ паралель уртрагийн дагуу чиглэлтэй, тектоник хагарлын нөлөөгөөр үүсэж, сунаж тогтсон түрүү палеозойн Хэрлэнгийн бүрдлийн лейкократ боржин дахь гидротермаль кварц-флюоритын биетүүд юм.

Хүдрийн биетүүд нь жижиг-дунд-том талстат жонш янз бүрийн туяатай балан шар, бэхэн ягаан, ногоон өнгөтэй, хүдрийн текстур нь цул, брекчи маягийн туузан байна. Судлын захын хэсгүүдээр брекчи маягийн хүдэр, төв хэсгээр нь цул текстуртэй хүдэр тархана. Цайвар өнгийн жонш захын хэсгээр, том хэсэгтээ ногоон байна. Жоншны талстын хэмжээ 3-5 см хүрнэ.

### 2.1 НӨӨЦ ТООЦСОН ҮНДСЭН ЗАРЧИМ БА ҮНДЭСЛЭЛ

Хавтгай-III хайлуур жоншны орд нь 3 хүдрийн биетээс тогтоно.

**Хүдрийн биет 1:** Уг хүдрийн биет нь кварц-флюоритын судал хэлбэрээр өргөргийн дагуу 240 м урттай, 3.9 м дундаж зузаантай байх ба хүдрийн биетийн уналын өнцөг  $67^{\circ}$ , хайлуур жоншны дундаж агуулга 40.36% байна. Хүдрийн биетийг хайгуулын 6 шугамаар, 87 м хүртэл гүнтэй өрөмдсөн байдаг. Хүдрийн биетийн хайлуур жонш нь жижиг-дунд, дунд, том талст үүсгэх ба ногооноос балан шаргал өнгөтэй байна. Хүдрийн биетийн хэмжээнд боломжтой  $C_2$  зэрэглэлээр 144.9 мян.тн хүдэрт 40.36%-ийн агуулгатай 58.5 мян.тн хайлуур жонш агуулагдана. Хүдрийн биетийг дагасан жижиг салбар судлууд орших ба уг салбар биетүүдэд нөөцийг тооцоогүй байна. Уг хүдрийн биет нь 1980-1990 оны хооронд Бэрхийн уурхайн олборлолтонд өртсөн, 2016-2018 оны намар хүртэл хувиараа жонш олборлогч (нинжа) нар гадаргуу орчимд олборлолт явуулсан байдаг. Нөөцийн тооцоог тооцохдоо олборлолтонд өртсөн хэсгийг хасч тооцсон болно.

**Хүдрийн биет 2:** Хүдрийн биет-2 нь мөн адил кварц-флюоритын судал бөгөөд хүдрийн биет-1-ээс зүүн тийш 22.0-77.0 м зайд байрлана. Уг хүдрийн биет нь баруун хойш

322<sup>0</sup> азимутаар, 163 м урттай сунаж тогтсон, 4.6 м дундаж зузаантай, 36.74%-ийн агуулгатай бэхэн ягаан өнгийн, дунд том мөхлөгт хайлуур жонш агуулдаг. Хайлуур жонш нь агуулагч боржингийн хил зааг орчимд брекчи маягийн хүдэр агуулдаг. Хүдрийн биет-2-ын хэмжээнд хайгуулын ажлын үр дүнгээр боломжтой С зэрэглэлийн үлдэгдэл нөөцийг 70.6 мян.тн хүдэрт 36.74%-ийн агуулгатай 25.9 мян.тн хайлуур жонш байна гэж тооцсон байна. Уг хүдрийн биет нь дээрх хугацаануудын адил хугацаанд гадаргуу хэсгээс олборлолтонд өртсөн.

**Хүдрийн биет 3:** Энэ биет нь хүдрийн биет-2-той паралель 13.0-16.0 м зайтай оршино. Хүдрийн биет-3 нь БХ328<sup>0</sup> азимутаар, баруун тийш 70<sup>0</sup> уналын өнцөгтэй, 150 м урттай сунаж тогтоно. Хайлуур жоншны хувьд том кристаллаг, ногоон өнгөтэй жонш зонхилох ба хүдрийн биетийг дагасан нарийн (прожилка) судланцрууд таарна. Хүдрийн биет-3-ын хэмжээнд боломжтой С зэрэглэлийн нөөцийг 78.1 мян.тн хүдэрт 49.27%-ийн агуулгатай 38.5 мян.тн хайлуур жоншны нөөц тогтоогдсон байна.

## 2.2 НӨӨЦИЙН ТООЦООНЫ ҮР ДҮН

Хавтгай-III хайлуур жоншны ордын I-III хүдрийн биетүүдийн MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хамрагдах хэсэгт нөөцийг тооцжээ. Ингэхдээ блок бүрийн хүдрийн биетийн дундаж зузаан, хайлуур жоншны агуулгыг тус тусад нь хүснэгтэнд оруулан тооцож хавсаргасан ба хүдрийн биет тус бүрээр нөөцийг тооцсон байна.

Нөөцийн тооцоог геологийн блокийн аргаар, боломжтой /С/ зэрэглэлээр хүдрийн биет тус бүрээр тооцож гаргасан байна. Хавтгай-III хайлуур жоншны ордын I-III хүдрийн биетүүдийн хэмжээнд дунджаар 41.86%-ийн CaF<sub>2</sub>-ын агуулгатай, нийт С зэрэглэлээр 293.58 мян.тн хүдэрт 122.89 мян.тн хайлуур жонш агуулагдаж байна гэж үзжээ. Тооцооны дүнд боломжтой /С/ зэрэглэлээр тогтоогдсон хайлуур жоншны нөөц болон баялаг нь “Ресурс партнерс групп” ХХК-ийн эзэмшиж буй Хавтгай-III хайлуур жоншны ордын I-III хүдрийн биетүүдийг хамарсан MV-021578 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамрагдаж байна.

Хүснэгт – 1. Хавтгай-III хайлуур жоншны ордын нөөцийн нэгдсэн хүснэгт

Д/д	Блокийн дугаар	Жинхэнэ зузаан (м)	Хөндлөн огтлолын талбай (м <sup>2</sup> )	Эзлэхүүн (м <sup>3</sup> )	Эзлэхүүн жин (тн/м <sup>3</sup> )	Хүдрийн хэмжээ (тн)	Дундаж агуулга	Хайлуур жоншны нөөц
							CaF <sub>2</sub> (%)	CaF <sub>2</sub> (тн)
<b>Хүдрийн биет I</b>								
1	С-I-1	3.90	13,579	52,958.1	2.736	144,893.4	40.36	58,479.0
<b>Хүдрийн биет II</b>								
2	С-II-1	4.59	5,727	26,286.9	2.685	70,580.4	36.74	25,931.2
<b>Хүдрийн биет III</b>								
3	С-III-1	3.46	8,426	29,154.0	2.679	78,103.5	49.27	38,481.6
<b>Ордын хэмжээнд С зэрэглэлээр</b>								
<b>Нийт</b>		<b>3.91</b>	<b>27,732</b>	<b>108,399.0</b>	<b>2.708</b>	<b>293,577.2</b>	<b>41.86</b>	<b>122,891.8</b>

### 3. УУРХАЙН ТӨЛӨВЛӨЛТ

#### 3.1 АШИГЛАЛТЫН СИСТЕМ

Орд нь III бүлгийн орд бөгөөд хүдрийн биет нь 3 хэсгээс бүрддэг. Газрын гадаргад ил гарсан гарштай, гаршийн хамгийн өргөн нь 17 м, ордын хэмжээнд дунджаар 4 м өргөнтэй ба хүдрийн биетүүд нь гол хэсэгтээ өргөн, 2 захруугаа нарийсаж үүссэн байна. Хүдрийн биетүүдийн хамгийн гүн хэсэг нь 75 м, уналын өнцөг нь  $39-86^0$  хооронд, дунджаар 63 градусын босоо уналтай. Хамгийн урт биет нь хойноос урагш чиглэлд 243 м урт сунаж тогтсон байна.

Лабораторийн шинжилгээгээр агуулагч чулуулгийн бат бэхийн итгэлцүүр нь  $f=5.44$ , хүдрийн бат бэхийн итгэлцүүр нь  $f=5.53$  байна. Ордод өрөмдсөн цооногийн мэдээллээр гүний болон гадаргын ус илрээгүй, ан цавжилт багатай байна. Хавтгай-III хайлуур жоншны ордын уул-геологийн нөхцөл, захиалагчийн бэлэн байгаа техникүүдийг харгалзан ордыг ил аргаар, автотээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар төлөвлөв.

Орд нь III бүлгийн орд тул боломжтой С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж ил уурхайн хүрээ хязгаарыг үүсгэв. Ил уурхайн хүрээнд 290.61 мян.тн геологийн нөөц хамрагдаж байна.

*Хүснэгт – 2. Уурхайн хүрээнд байгаа геологийн нөөцийн хэмжээ*

№	Блокийн дугаар	Ашигт малтмалын дундаж зузаан		Ашигт малтмалын нөөц		Эрдэс
		м	мян.м <sup>3</sup>	мян.тн	мян.тн	
1	C-1	3.90	52.22	142.87	57.66	
2	C-2	4.59	26.29	70.58	25.93	
3	C-3	3.46	28.80	77.15	38.01	
<b>Боломжтой С зэрэглэлийн нөөц</b>		<b>4</b>	<b>107.31</b>	<b>290.61</b>	<b>111.64</b>	

Ил уурхайн хүрээний гадна 1.09 мян.м<sup>3</sup> буюу 2.97 мян.тн хайлуур жонш үлдсэн. Үлдэж буй нөөцийн хэсэг нь хүдрийн биет-1-ийн ёроолд +1190 м-ээс доош +1165 м хүртэл орших хэсэг бөгөөд уг хэсгийн нөөц нь гүн рүүгээ нарийсаж гурвалжин шовх үзүүртэй болон дуусдаг. Нөөцийг бүрэн авах хувилбаар тооцож үзэхэд уурхайн гүн ихсэж хөрс хуулалт нэмэгдсэн ба үлдэгдэл авах нөөцийн хэмжээ 1.09 мян.м<sup>3</sup>, нэмэгдэх хөрсний хэмжээ 240.22 мян.м<sup>3</sup> болж тухайн хэсгийн хөрс хуулалтын итгэлцүүр  $80.88 \text{ м}^3/\text{тн}$ ,  $221.19 \text{ м}^3/\text{м}^3$  болсон, мөн ил уурхайн гүн 80 м хүрч гүнзгийрэх тул уг хэсгийн нөөцийг ил уурхайн хүрээний гадна үлдэж буй нөөцийн хэмжээнд оруулж тооцсон.

### 3.2 Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Хавтгай-III хайлуур жоншны ордын боломжтой С зэрэглэлийн нөөцөд тулгуурлаж хаягдал, бохирдол тооцсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын дагуу боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадалсан В' үйлдвэрлэлийн нөөц нь **294.12 мян.тн** хүдэр байна. Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр 6.92 м<sup>3</sup>/м<sup>3</sup> буюу 2.55 м<sup>3</sup>/тн болж байна.

Хүснэгт - 3. Ил уурхайн жонш олборлолтын үеийн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Геологийн нөөц									Ил уурхайн хүрээний гадна үлдэх нөөц		Ашиглалтад өртөх нөөц		Хаягдал			Бохирдол		Үйлдвэрлэлийн нөөц					
№	Блокийн дугаар	Блокийн талбай	Ашигт малтмалын дундаж зузаан	Ашигт малтмалын эзлэхүүн	Эзлэхүүн жин	Ашигт малтмалын нөөц	Дундаж агуулга	Эрдэс	Ашигт малтмалын нөөц	Эрдэс	Ашигт малтмалын нөөц	Эрдэс	Хувь	Хаягдах нөөц	Эрдэс	Хувь	Бохирдлын хэмжээ	Блокийн дугаар	Хөрсний эзлэхүүн	Нөөц		Дундаж агуулга	Эрдэс
																				мян.тн	мян.тн		
Хэмжих нэгж	мян.м <sup>2</sup>	м	мян.м <sup>3</sup>	тн/м <sup>3</sup>	мян.тн	%	мян.тн	мян.тн	мян.тн	мян.тн	мян.тн	мян.тн	%	мян.тн	мян.тн	%	мян.тн		мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.тн	%	мян.тн
1	С-1	13.58	3.90	52.96	2.736	144.89	40.36	58.48	2.02	0.81	142.87	57.66	2.42	3.46	1.40	3.63	5.18	В'-1	752.34	52.85	144.60	38.91	56.27
2	С-2	5.73	4.59	26.29	2.685	70.58	36.74	25.93	-	-	70.58	25.93	2.42	1.71	0.63	3.63	2.56	В'-2		26.60	71.43	35.42	25.30
3	С-3	8.43	3.46	29.15	2.679	78.10	49.27	38.48	0.95	0.47	77.15	38.01	2.42	1.87	0.92	3.63	2.80	В'-3		29.15	78.09	47.50	37.09
<b>Боломжтой С нөөц</b>		<b>27.73</b>	<b>3.91</b>	<b>108.40</b>	<b>2.70</b>	<b>293.58</b>	<b>41.9</b>	<b>122.89</b>	<b>2.97</b>	<b>1.28</b>	<b>290.61</b>	<b>121.61</b>	<b>2.42</b>	<b>7.03</b>	<b>2.94</b>	<b>3.63</b>	<b>10.55</b>		<b>752.34</b>	<b>108.60</b>	<b>294.12</b>	<b>40.35</b>	<b>118.67</b>

### 3.3 Уурхайн жилийн хүчин чадал

Хавтгай-III хайлуур жоншны ордыг олборлох ил уурхайн жилийн хүчин чадлыг төсөл хэрэгжүүлэгчийн ТЭЗҮ-ийг боловсруулах техникийн даалгаварт тусгасны дагуу, мөн тус компанид бэлэн байгаа тоног төхөөрөмжийн хүчин чадалтай уялдуулан жилд хамгийн ихдээ **193.0** мян.тн хүдэр олборлохоор тооцов.

Ил уурхайн олборлолтын ажлыг төлөвлөсөн хүчин чадлаар тооцоход **2** жилийн хугацаанд нийт үйлдвэрлэлийн хүдрийн нөөцийг олборлохоор байна.

### 3.4 Уурхайн ажиллах горим

Уурхайн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногуудад амрах ба, цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Хүснэгт5. Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа

Хоног, зориулалт	Уурхайн 1 дэх жилд ажиллах боломжтой хоног									Жилд
	3	4	5	6	7	8	9	10	11	
Хуанлийн хоног	31	30	31	30	31	31	30	31	30	275
Баяр ёслол	0	0	0	0	5	0	0	0	0	5
Цаг агаарын хүндрэл	0	0	1	0	2	1	0	0	0	4
<b>Ажлын өдөр</b>	<b>31</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>24</b>	<b>30</b>	<b>30</b>	<b>31</b>	<b>30</b>	<b>266</b>

### 3.5 ХҮДЭР ОЛБОРЛОЛТЫН АЖЛЫН КАЛЕНДАРЬ ТӨЛӨВЛӨЛТ

Хавтгай-III хайлуур жоншны ордыг Ил уурхайн жилд ажиллах хоногоос хамаараад хөрс хуулалт, хүдэр олборлолт, уурхайн ахилт харилцан адилгүй ба уулын ажлын календарьчилсан төлөвлөлтийг боловсруулж уурхайн ашиглалтын жилүүдийн календарьчилсан төлөвлөгөөг хүснэгт №6-д үзүүлэв..

*Хүснэгт -6. Ил уурхайн жонш олборлолтын календарьчилсан төлөвлөлт*

Ашиглалтын жилүүд	Хөрс хуулалт		Хүдэр олборлолт			Уулын цул	Хөрс хуулалтын дундаж итгэлцүүр	
	Хөрс	Шимт хөрс	Блоккийн дугаар	мян.м <sup>3</sup>	мян.тн		мян.м <sup>3</sup>	м <sup>3</sup> /м <sup>3</sup>
Хэмжих нэгж	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>						
1 дэх жил	247.00	7.40	С-1	11.8	32.3	291.90	6.59	2.44
			С-2	12.3	33.1			
			С-3	13.4	35.9			
			<b>Нийт С</b>	<b>37.5</b>	<b>101</b>			
2 дахь жил	505.34		С-1	41.06	112.34	576.44	7.11	2.62
			С-2	14.29	38.37			
			С-3	15.75	42.20			
			<b>Нийт С</b>	<b>71.1</b>	<b>192.9</b>			
<b>Нийт</b>	<b>752.34</b>	<b>20.53</b>		<b>108.60</b>	<b>294.1</b>	<b>868.34</b>	<b>6.92</b>	<b>2.63</b>

### 3.6 ил уурхайн технологийн үндсэн процессууд

Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагаа нь дараах процессын дарааллаар явагдана.

*Хүснэгт №7. Ил уурхайн процесс*

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Автотээвэр экскаваторын хослол бүхий, гадаад овоолготой ашиглалтын систем	1. Хөрс хуулалт	1.1. Шимт хөрсийг хуулах 1.2. Шимт хөрсийг ачих 1.3. Шимт хөрсийг тээвэрлэх 1.4. Өрөмдлөг тэсэлгээ хийх 1.5. Хөрсийг ухаж ачих 1.6. Хөрсийг тээвэрлэх 1.7. Гадаад овоолгод хураах 1.8. Овоолгыг түрэн тэгшлэх
	2. Хүдэр олборлолт	2.1. Өрөмдлөг тэсэлгээ хийх 2.2. Хүдрийг ухаж ачих 2.3. Тээвэрлэх 2.4. Баяжуулах хэсгийн түр овоолгод буулгах 2.5. Хүдрийг ялгаж баяжмал, бага агуулгатай хүдрийг гаргах 2.6. Жоншны баяжмал болон бага агуулгатай хүдрийг тээвэрлэх

#### 4. ХҮДЭР АНГИЛАН ЯЛГАЛТ

Хавтгай-III уурхайгаас олборлох хайлуур жоншны хүдрийг гар аргаар ялгах технологийн шийдлийг судалгаа шинжилгээний “Эпсилонмет” ХХК-ийн хийсэн технологийн туршилтанд үндэслэн шийдвэрлэсэн. Дээрх технологийн туршилтаар флотацийн аргаар баяжуулах туршилт явуулсан бөгөөд энэ арга нь анхдагч хөрөнгө оруулалт өндөр, зардал ихтэй зэргээс шалтгаалан ордын хүдрийг гар аргаар ялгаж, өндөр агуулгатай бүхэллэг сортын жоншийг гарган авахаар төлөвлөсөн.

Энэ арга нь флотацийн аргатай харьцуулахад зардал багатай, эдийн засгийн хувьд үр ашигтай арга юм.

Баяжуулах хэсгийн хүчин чадлыг уурхайгаас олборлож буй хүдрийн хэмжээнээс хамааруулан эхний жилд 101.21 мян.тн, 2 дахь жилд 192.91 мян.тн/жил байхаар ТЭЗҮ-д тусгаж технологийн болон тоног төхөөрөмжийн тооцооллуудыг гүйцэтгэлээ. Уурхайн баяжуулах хэсэг нь жил бүр 2 ээлжээр, 12 цагаар ажиллана. Баяжуулах хэсэг нь уурхайн баруун талд байрлана. Баяжуулах хэсгийн ажиллах горимыг хүснэгт №61-д үзүүлээ.

Уурхай нь нийт 2 жилийн хугацаанд ажиллах ба эхний жилд бичиг баримтын бүрдлээс шалтгаалан 139 хоног, 2 дахь жилд 253 хоног ажиллана. Ашиглалтын 2 жилийн хугацаанд олборлох хүдрийн хэмжээг ажиллах хоногт нь харьцуулан цагийн хүчин чадлыг тодорхойлсон бөгөөд жил тус бүрийн хамгийн их хүчин чадлаар баяжуулах хэсгийн хүчин чадлын тооцоог хийж гүйцэтгэв.

##### 4.1 БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ


Хавтгай-III уурхайгаас олборлох хайлуур жоншны хүдрийг гар аргаар ялгах технологийн шийдлийг судалгаа шинжилгээний “Эпсилонмет” ХХК-ийн хийсэн технологийн туршилтанд үндэслэн шийдвэрлэсэн. Дээрх технологийн туршилтаар флотацийн аргаар баяжуулах туршилт явуулсан бөгөөд энэ арга нь анхдагч хөрөнгө оруулалт өндөр, зардал ихтэй зэргээс шалтгаалан ордын хүдрийг гар аргаар ялгаж, өндөр агуулгатай бүхэллэг сортын жоншийг гарган авахаар төлөвлөсөн.

Энэ арга нь флотацийн аргатай харьцуулахад зардал багатай, эдийн засгийн хувьд үр ашигтай арга юм.



## 4.2 БАЯЖУУЛАХ ТЕХНОЛОГИЙН СХЕМ

Хүдэрт хийгдсэн бодисын найрлагын судалгаа, агуулагч чулуулгийн судалгаа болон технологийн туршилтын үр дүнд үндэслэн тус ордын хүдрийг нэг шатны бутлалт, нэг шатны шигшилт хийсний дараа бүхэллэг жоншийг гар аргаар ялгах нь оновчтой гэж үзлээ.



Уурхайгаас ирэх хүдрийн хамгийн том ширхэглэл -320 мм байх ба хүдрийг нэг шатны бутлалт, нэг шатны шигшилт хийсний дараа +50 мм ширхэглэл бүхий хэсгийг гар аргаар ялгалт хийж ФК-85 маркийн баяжмал болон бага агуулгатай хүдрийг ялган авна.

Анхдагч хүдрээс хайлуур жоншийг гар аргаар ялгах болсон нь хүдрийн шинж чанар, агуулагч чулуулаг болон хүдрийн найрлагын судалгаа шинжилгээний үр дүн, хайлуур жоншны бүхэллэг шинж зэргээс хамаарч байгаа ба гар ялгалт хийсэн туршилтын үр дүн зэрэгт үндэслэн бүтээгдэхүүний гарц, жонш авалт болон агуулгыг тогтоосон болно.

### 4.3 БҮТЭЭГДЭХҮҮН ГАРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайгаас олборлосон 40.35%-ийн дундаж агуулга бүхий 294.12 мян.тн хүдрийг буталж, шигшин бүхэллэгээр ангилсаны дараа гар аргаар ялган ФК-85 маркийн бүхэллэг жоншны баяжмалыг гарган авна. Бүтээгдэхүүн гаргалтын хувьд ФК-85 маркийн баяжмалын хэмжээ 73.53 мян.тн, бага агуулгатай буюу 25.46%-ийн агуулгатай хүдэр 220.59 мян.тн-ыг гаргахаар тооцсон. Бүтээгдэхүүн гаргалтын дэлгэрэнгүй тооцооллыг хүснэгт №12-д үзүүлэв.

Хүснэгт 12. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд								Нийт	
		1 дэх жил				2 дахь жил					
Блокийн дугаар			С-1	С-2	С-3	Нийт	С-1	С-2	С-3	Нийт	
Хүдэр	Хэмжээ	мян.тн	32.27	33.06	35.89	101.21	112.34	38.37	42.20	192.91	294.12
	Агуулга	%	38.91	35.42	47.50	40.82	38.91	35.42	47.50	40.10	40.35
Баяжмал /ФК -85/	Гарц	%	25.00	25.00	25.00	25.00	25.00	25.00	25.00	25.00	25.00
	Агуулга	%	85.00	85.00	85.00	85.00	85.00	85.00	85.00	85.00	85.00
	Хэмжээ	мян.тн	<b>8.07</b>	<b>8.27</b>	<b>8.97</b>	<b>25.30</b>	<b>28.08</b>	<b>9.59</b>	<b>10.55</b>	<b>48.23</b>	<b>73.53</b>
Бага агуулгатай хүдэр	Гарц	%	75.00	75.00	75.00	75.00	75.00	75.00	75.00	75.00	75.00
	Агуулга	%	24.56	22.35	29.98	<b>25.76</b>	24.56	22.35	29.98	25.30	<b>25.46</b>
	Хэмжээ	мян.тн	<b>24.20</b>	<b>24.80</b>	<b>26.91</b>	<b>75.91</b>	<b>84.25</b>	<b>28.78</b>	<b>31.65</b>	<b>144.68</b>	<b>220.59</b>

## 5. ДЭД БҮТЭЦ БА УДИРДЛАГА

### 5.1. ЦАХИЛГААН ТЭЖЭЭГҮҮРИЙН СОНГОЛТ, ТООЦОО

*Цахилгаан хангамжийн эх үүсвэр:* Хавтгай-III хайлуур жоншны ордыг олборлох уурхайн хувьд баяжуулах хэсгийн тоног төхөөрөмж, ажилчдын хотхон, уурхайн гэрэлтүүлэг гэсэн хэсгүүдэд цахилгааны хэрэгцээ үүсэж байгаа бөгөөд цахилгаан хэрэглэгчдийг төвийн шугамтай холбогдосон эрчим хүчээр хангана.

*Хүснэгт №1. Цахилгаан хэрэглэгчдийн суурь болон тооцооны актив чадал*

№	Цахилгаан хэрэглэгчид	Тоо, ширхэг	Ажлын заасан чадал		Тооцооны итгэлцүүр			Тооцооны чадал			Ажиллах хугацаа, хоног			Цаг ашиглалтын итгэлцүүр	Цахилгаан хэрэглээ /1 дэх жил/		Цахилгаан хэрэглээ /2-3 дахь жил/	
			Рном, кВт	ΣРном, кВт	Кх	tgα	Ка.а	Рг, кВт	Qт, кВар	1 дэх жил	2 дахь жил	цаг	Wa, кВт		Wp, кВар	Wa, кВт	Wp, кВар	
<b>Баяжуулах хэсэг</b>																		
1	Хацарт бутлуур	1	55	55	0.90	1	0.85	49.5	42.08	145	266	20	0.8	114,840.00	97,614.00	210,672.00	179,071.20	
2	Шигшүүр	1	5.5	5.5	0.90	1	0.85	4.95	4.21	145	266	20	0.8	11,484.00	9,761.40	21,067.20	17,907.12	
3	Туузан конвейер	4	3	12	0.90	1	0.85	10.80	9.18	145	266	20	0.8	25,056.00	21,297.60	45,964.80	39,070.08	
4	Тоос баригч	1	5	5	0.90	1	0.85	4.50	3.83	145	266	20	0.8	10,440.00	8,874.00	19,152.00	16,279.20	
5	Тооцоологдоогүй хэрэглээ	1	3.43	3.43	0.90	1	0.85	3.08	2.62	145	266	20	0.8	7,151.40	6,078.69	13,119.12	11,151.25	
	<b>Дүн</b>	<b>7</b>		<b>80.93</b>				<b>72.83</b>	<b>61.91</b>					<b>168,971.40</b>	<b>143,625.69</b>	<b>309,975.12</b>	<b>263,478.85</b>	
<b>Цайны газар</b>																		
6	1-р хоолны тогоо	1	5	5	0.90	1	0.9	4.50	4.05	145	266	24	0.8	12,528.00	11,275.20	22,982.40	20,684.16	
7	2-р хоолны тогоо	1	5	5	0.90	1	0.9	4.50	4.05	145	266	24	0.8	12,528.00	11,275.20	22,982.40	20,684.16	
8	Хөргөгч	1	3	3	0.90	1	0.9	2.70	2.43	145	266	24	0.9	8,456.40	7,610.76	15,513.12	13,961.81	
9	Хөлдөөгч	2	3	6	0.90	1	0.9	5.40	4.86	145	266	24	0.9	16,912.80	15,221.52	31,026.24	27,923.62	
10	Цахилгаан тогоо	1	2.5	2.5	0.90	1	0.9	2.25	2.03	145	266	24	0.6	4,698.00	4,228.20	8,618.40	7,756.56	
11	Печь	1	1.5	1.5	0.90	1	0.9	1.35	1.22	145	266	24	0.5	2,349.00	2,114.10	4,309.20	3,878.28	
12	Ус буцалгагч	1	1.5	1.5	0.90	1	0.9	1.35	1.22	145	266	24	0.9	4,228.20	3,805.38	7,756.56	6,980.90	
13	Аяга таваг ариутгагч	1	1.5	1.5	0.90	1	0.9	1.35	1.22	145	266	24	0.9	4,228.20	3,805.38	7,756.56	6,980.90	
14	Жигнүүр	1	1.5	1.5	0.90	1	0.9	1.35	1.22	145	266	24	0.8	156.60	3,382.56	6,894.72	6,205.25	
15	Тооцоологдоогүй хэрэглээ	1	1.23	1.38	0.90	1	0.9	1.24	1.11	145	266	24	0.8	143.55	3,100.68	6,320.16	5,688.14	
	<b>Дүн</b>	<b>11</b>		<b>28.88</b>				<b>25.99</b>	<b>23.39</b>					<b>66,228.75</b>	<b>65,818.98</b>	<b>134,159.76</b>	<b>120,743.78</b>	
<b>Засвар үйлчилгээний хэсэг</b>																		
16	Гагнуурын аппарат	1	6	6	0.90	1	0.9	5.40	4.86	145	266	24	0.5	9,396.00	8,456.40	17,236.80	15,513.12	

17	Тасдагч (гом)	1	1.5	1.5	0.90	1	0.9	1.35	1.22	145	266	24	0.5	2,349.00	2,114.10	4,309.20	3,878.28
18	Тасдагч (жижиг)	2	3	6	0.90	1	0.9	5.40	4.86	145	266	24	0.5	9,396.00	8,456.40	17,236.80	15,513.12

## 6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

### 6.1 Уурхайн аюулгүй ажиллагаа

Хавтгай-III хайлуур жоншны ил уурхай нь Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, “Ашигт малтмалын ордыг ил аргаар олборлоход мөрдөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон “Ашигт малтмал, газрын хэвлийн тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль” тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, зааврын шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

ХАБЭА-тай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах хууль, тогтоомж, стандартын шаардлагын дагуу, тэдгээрийн хүрээнд ажиллана. Зарим дүрэм, стандартын талаар дурдвал,

- Монгол Улсын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль
- ХАБЭА. Нэр томъёо, тодорхойлолт, MNS 4967:2000
- ХАБЭА. Ерөнхий шаардлага, MNS 4968:2000
- ХАБЭА–н удирдлагын тогтолцоо, OHSAS18001:2007 (Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хамруулан MNS-OHSAS 18001: 2012 тоот Монгол Улсын стандарчлалын үндэсний зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан байдаг. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээ /ХЭМАБ/ бүхий аж ахуй нэгж байгууллагуудтай холбоотой өөрсдийн эрсдэлийг хянаж, үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг бүрдүүлэх ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны шаардлагыг тогтоосон байна).
- ХАБЭА. Сургалтын зохион байгуулалт, үндсэн дүрэм, MNS 4969:2000
- ХАБЭА. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага, MNS 4990:2023
- ХАБЭА. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага, MNS 5105:2001
- Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм, MNS 5566:2020
- Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага, MNS 5390:2004
- ХАБЭА. Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага, MNS ISO 13688:2000

## **6.2. Ил уурхайн – хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй**

Шинээр барьсан болон өргөтгөсөн уулын үйлдвэр, барилга байгууламжийг эрх бүхий комисс дүгнэлт гаргуулж ашиглалтад хүлээж авна.

Ажлын байр, зам, гарам нь хүн чөлөөтэй зорчиход саадгүй, гэнэтийн аюул ослын үед хүн, машин техникийг яаралтай зайлуулах боломжтой байна.

Ээлж солилцох цагаар буюу удаан хугацаагаар ажиллахгүй тохиолдолд уул-тээврийн болон зам барилгын машин механизмыг догол мөргөцгөөс зайлуулан аюулгүй газарт байрлуулж тэдгээрийн ажлын хэсгийг (утгуур, хусуур зэрэг) газарт буулган хаалга үүдийг түгжиж, тэжээлийн кабелийн хүчдэлийг салгана.

Машин тоног төхөөрөмжийг эргэх буюу хөдөлгөөнтэй хэсгүүдийн хаалт, хамгаалалт байхгүй үед ажиллуулахыг хориглоно. Хий, шингэн, дулаан, цахилгаан эрчим хүчний тэжээлийг салгаж, эд ангийн хөдөлгөөн бүрэн зогссоны дараа машин механизмд үзлэг, үйлчилгээ, засварын ажил хийнэ. Засварын ажлын явцад хий, шингэний даралт, дулаан, цахилгааны эрчим хүч гэнэт залгагдах бүх боломжийг урьдчилан арилгасан байх ёстой.

Ажлын байранд агаарын тоос, хорт хийн хэмжээ нь эрүүл ахуйн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх, тэсрэх аюултай нөхцөл бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх ёстой. Уурхайд гал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч байх ёстой. Уурхай бүр гал гарсан үед шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх галын бүлгэм, галын техникийн комиссыг зохион байгуулна.

Уулын үйлдвэр, уурхай бүр өөрийн онцлогт тохирсон “Аваар устгах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын дагуу боловсруулсан аваар устгах төлөвлөгөөтэй байна. Аваар устгах төлөвлөгөөнд гал унтраах ажлыг хэрхэн зохион байгуулах тухай заавал тусгасан байна. Даралтат сав, уурын зуух, ачаа өргөх кран, цахилгаан болон дулааны тоног төхөөрөмжүүдийг байрлуулах, тоноглох, ашиглах үед “Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрэм”, “Уур усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрэм”, “Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн шаардлагыг баримтална.

Үерийн усны болзошгүй аюул бүхий уурхайд хамгаалалтын арга хэмжээг урьдчилан авна. Үерийн уснаас хамгаалах суваг, далан хаалт байгуулах, үерийн урсгал гарах талбайн гадаргыг өөрчлөх ажлыг хэрэгжүүлнэ. Үерийн аюулаас хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг ордын нөхцөлтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

Нуралт, гулсалт гарч болзошгүй овоолгын аюултай бүсэд инженерийн байгууламж, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно. Овоолох чулуулаг ба суурь талбайн чулуулгийн физик-механикийн шинж чанар, газар зүйн байдал, овоолох арга технологитой уялдуулан овоолгын өндөр, хажуугийн налуу, нурлын бүс, мөргөцгийн ахилтын хурдыг тодорхойлно.

Овоолгын чулуулгийн тогтворжилтыг системтэй хянах ажиллагааг уурхайн геологи-маркшейдерийн алба гүйцэтгэнэ. Уурхайн ерөнхий инженерийн баталсан уулын ажлын паспортгүйгээр экскаватораар ажил гүйцэтгэхийг хориглоно. Уг паспортад доголын өндөр, ажлын талбайн өргөн, налууугийн хэмжээ, уул-тээврийн машины тэнхлэгээс мөргөцгийн болон овоолгын ирмэг хүртэлх зай, нурах аюултай бүсийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг тусгахаас гадна экскаваторын болон тээврийн хэрэгслийн ажиллах зарчим, бүдүүвчийг харуулна. Догол мөргөцгийн байдалд өөрчлөлт гарсан үед паспортыг шинэчилнэ. Экскаваторын ажиллагааны үед түүний эргэх тойргийн хүрээнд хүмүүс байхыг хориглоно.

#### ***Ил уурхайн аюулгүйн ажиллагаанд баримтлах арга хэмжээнүүд***

Уурхайн хажуу, догол, овоолгын тогтворжилтыг хангахын тулд доорх арга хэмжээг авч явуулна. Үүнд:

- Доголын нурж болзошгүй тохиолдлуудыг цаг тухайд нь аюулыг зайлуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, гулсалт гарч болох газруудад анхааруулах тэмдэг хадсан байх
- Овоолгын талбайг байнга тэгшлэн, арчилж байхаас гадна овоолгыг цас бороо, үер, уснаас хамгаалах шуудуу байгуулна.
- Ил уурхай болон хөрсний овоолго, дэд бүтцийн барилга байгууламжуудыг гадаргын уснаас хэрхэн хамгаалах, усны шуудууг ус орж ирэх боломжтой бүх талаас нь татан хамгаалсан байна.

#### ***Осол, авартай тэмцэх арга хэмжээ***

Үйлдвэрийг осол аваргүй ажиллуулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Үйлдвэрлэлийн ажил явуулах явцад техник аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж, хүн бүрийг техник аюулгүй ажиллагааны дүрэмтэй танилцуулж, сургасан байна.

- Автомашин болон тээврийн бусад хэрэгсэл нь овоолго дээр чулуулгийн гулсах зурвасын дагуу гадна хүрээнд зогсон ачаагаа буулгах ба гулсах зурвасын өргөнийг маркшейдерийн хэмжилтээр тогтоон, ажилчдад мэдээлж байна.
- Уулын ажлыг уурхайн ашиглалтын мэргэжлийн хүний удирдлагын дор явуулна.
- Уулын бүх машин техникүүд нь эмийн сантай байх ба шаардлагатай эмийн зүйлээр хангагдсан байна.
- Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны талаар ажилчдад тогтмол зааварчилгаа өгч гарын үсэг авсан байна.
- Удирдлагаас үйлдвэрлэлийн бүх ажиллагаанд аюулгүй ажиллагааны дүрэм хатуу чанд мөрдөгдөж байгаад тогтмол хатуу хяналт тавьж ажиллана.

### **6.3. УУЛЫН ҮЙЛДВЭРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА**

ХАБЭА-н тухай холбогдох хууль, дүрэм, журам, “Ил уурхайн аюулгүй байдлын дүрэм”, “Ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хууль, “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасан шаардлага, нөхцөлүүдийг бүрэн хангаж ажиллана.

Уурхайн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагуудын хэрэгжүүлэлтэд хяналт тавих зорилготой ХАБЭА-н орон тоог бий болгох ба уг ажилтан нь уурхайн даргын шууд удирдлага дор ажилладагаас гадна орон тооны бус ХАБЭА-н зөвлөл, үйлдвэрийн ослыг судлан бүртгэх комисс байгуулж ажиллана.

#### **Уул уурхайн машин тоног төхөөрөмж дээр ажиллах аюулгүй ажиллагаа**

1. Уул-тээврийн болон машин тоног төхөөрөмж нь эвдрэл гэмтэлгүй, хэвийн ажиллагаатай байхаас гадна дохиоллын болон хэт ачааллаас хамгаалах хэрэгсэл, галын багаж хэрэгсэл, хэмжилт, хяналтын хэмжүүрээр тоноглогдсон тормозын систем нь найдвартай ажиллагаатай, тодорхой ажиллах талбайтай байх бөгөөд харанхуй үед сайтар гэрэлтүүлэгдсэн байвал зохино.
2. Машин механизмын эргэх болон хөдлөх ил харагдах хэсгүүд нь хаалт хамгаалалттай байна. Машин механизмын ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдалд өдөр бүр машинч, долоо хоногт хэсгийн механик, сар тутам ерөнхий механик, түүний туслах, эсвэл захиргаанаас томилогдсон мэргэжилтэн шалгалт хийж үр дүнг ээлж хүлээлцэх дэвтэр, техник ашиглалтын паспорт, журналд тэмдэглэнэ. Бүрэн бус эвдрэл гэмтэлтэй, хэвийн бус ажиллагаатай машин тоног төхөөрөмж ажиллуулахыг хориглоно.



3. Аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нөхцөлд машин тоног төхөөрөмжийг хатуу холбоос хэрэглэн трактор, бульдозер, автомашинаар чирж нүүлгэхийг зөвшөөрнө. Онцгой хүнд жинтэй машин механизмыг бусад төрлийн холбоос хэрэглэн чирж зөөвөрлөх ажлыг үйлдвэрийн ерөнхий инженерийн баталсан зураг төсөл, схемийн дагуу гүйцэтгэнэ.

4. Машин тоног төхөөрөмжийг ажиллаж байх үед түүнд тосолгоо, үйлчилгээ хийхийг хориглоно.

Тайлбар: Аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан зориулалтын багаж хэрэгсэл ашиглаж машин тоног төхөөрөмжид ажиллаж буй үед нь тосолгоо үйлчилгээ хийхийг зөвшөөрнө.

Шугам хоолой, эд ангиудад хөлдсөн ус, тосыг гагнуурын дөл, задгай галаар халааж болохгүй.

5. Машин тоног төхөөрөмжийн цахилгаан дулааны эрчим хүч гэнэт тасарсан тохиолдолд түүнийг ажиллуулагч тэжээлийн хэлхээг салгах буюу удирдлагын аппарат хэрэгсэл, залгууруудыг "Зогс" гэсэн байдалд даруй шилжүүлэх үүрэгтэй.

6. Уул, тээврийн машин ажиллаж байх үед удирдах болон хянах үүрэг бүхий ажилтнаас бусад гадны хүн машины бүхээг, ажиллах талбай, ойр орчинд байхыг хориглоно.

7. Арчих, тослох материалыг машин механизм дээр таглаатай төмөр саванд хадгална. Уул тээврийн машин механизм дээр галд хялбар авалцах, тэсрэх аюултай, химийн хортой зүйлс хадгалахыг хориглоно.

8. Уул тээврийн машин тоног төхөөрөмжийн шат тавцан, эд ангиудыг уулын чулуулгийн жижиг хэсгүүд, шороо тоос, хог хаягдлаас байнга цэвэрлэж байвал зохино.

9. Хоорондоо ажлын уялдаа холбоо бүхий уул тээврийн машин түүнчлэн тэдгээрт засвар үйлчилгээ хийх зориулалттай машин тоног төхөөрөмж нь хүч чадал, ажлын хэсгийн овор хэмжээ, техникийн үндсэн үзүүлэлтийн хувьд харилцан тохирч байх шаардлагатай.

10. Үйлдвэрийн ерөнхий инженерийн баталсан уулын ажлын паспортгүйгээр экскаватороор ажил гүйцэтгэхийг хориглоно. Уг паспортад доголын өндөр, ажлын талбайн өргөн, налуугийн хэмжээ, уул тээврийн машины тэнхлэгээс мөрөцөгийн болон овоолгын ирмэг хүртэлх зай, нурах аюултай бүсийн хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг тусгахаас гадна экскаваторын болон тээврийн хэрэгслийн ажиллах зарчим, бүдүүвчийг харуулна. Догол мөрөгцөгийн байдалд өөрчлөлт гарсан үед паспортыг шинэчилнэ.

11. Экскаваторын операторчны үнэмлэхтэй, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж зааварчилга авсан, техникийн паспорттай танилцсан тухай гарын үсэг зурсан ажилтан экскаватор жолоодно.
12. Гэмтэлтэй буюу бүрэн бус экскаватороор ажиллахыг хориглоно. Экскаваторын машинч нь ажиллахад тохиромжтой, цэвэр, шатах тослох материалд нэвчээгүй ажлын хувцастай ажиллана.
13. Экскаваторын бүхээгт шатах материал хадгалж болохгүй.
14. Экскаваторын машинистын үнэмлэхгүй этгээдэд жолоо шилжүүлэх, биеийн байдал хэвийн бус, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн машинч экскаватор жолоодохыг хориглоно.
15. Ажил эхлэхийн өмнө дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:
  - a) экскаваторын эд анги ба зангилаанд гадны үзлэг хийх, мөн бэхэлгээний эд анги, хоолойны холбоос, хуваарилах хайрцаг, үе ба хуруу, түүнчлэн гинж, тоормосыг чангалах, дугуйны байдал, дуут дохио болон бүхээгний хаалганы цоожны бүрэн бүтэн эсэх;
  - b) түлш, тос, ус гоожиж байгаа эсэх
  - c) зангилаа ба эд ангийн бэхэлгээг шалгаж шаардлагатай арга хэмжээг авах;
  - d) бүхээгний шил ба гэрэл чийдэнг тоос шорооноос цэвэрлэх;
  - e) цахилгаан тоног төхөөрөмжийн утасны бүрэн бүтэн байдалд үзлэг хийх;
  - f) аккумуляторын тоос шороог цэвэрлэж шонгийн бэхэлгээ, мөн түүнчлэн электролитийн түвшинг шалгах;
  - g) ажлын тоног төхөөрөмж (утгуур, сум, өргөх ба эргэх механизм)-ийн бүрэн бүтэн байдлыг шалгах.
16. Машинч өөрөө засаж чадахгүй эвдрэл гэмтэл гарсан байвал механик буюу ээлжийн мастерт мэдэгдэж бүрэн засаж дуустал ажил эхэлж болохгүй. Эвдрэл гэмтлийг засах талаар хийсэн засварын ажлыг засвар, үйлчилгээний журналд тэмдэглэнэ.
17. Хөргөх систем рүү керосин, дизелийн түлш бусад нефть бүтээгдэхүүн хийхийг хориглоно.

### **Авто тээвэр**

1. Авто замын байгууламж нь зам барилгын норм хэмжээнд тохирсон байна. Ил уурхайн авто замын байгууламж, хучилт, замын өргөн налуу зэргийг зураг төсөлд тодорхой тусгасан байна. Авто замын суурийг тогтвортой хатуу чулуулгаар хийнэ. Суурийн өргөн, өндрийн хэмжээ нь ажиллах автомашины төрөл, даац зэргээс хамаарч төслөөр тогтоогдоно.

- Ил уурхайн авто замын налуугийн хэмжээ нь техник, эдийн засгийн тооцоогоор, хөдөлгөөний аюулгүй байдал, техник ашиглалтын дүрэм, зааврын шаардлагыг хангасан байхаар тогтоогдох бөгөөд автомашины хувьд 0.08-аас, онцгой тохиолдолд 0.10-аас ихгүй байна.
- Автозамын мурийлтын радиус нь автомашины даацаас хамаарч хүснэгт №87-д үзүүлсэн хэмжээнээс багагүй байна.

Хүснэгт №2. Авто замын мурийлт

Замын нөхцөл	Мурийлтын радиус, м
	Автосамосвалын даац
	25-30
Байнгын замд	50-60
Чиглэл өөрчлөх мурий замд	20-30
Уурхайн дотоод түр замд	12-15
Мөрөгцөг дэх сэлгээ хийх замд	10-11

- Ил уурхайн авто тээврийн ашиглалт, хөдөлгөөний байдалд "Замын аюулгүй байдлын тухай" Монгол улсын хууль, тогтоомж болон "Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм"-ийн заалтыг дагаж мөрдөнө. Автомашин нь техникийн хувьд бүрэн бүтэн байх бөгөөд ар талыг харах толь, гэрлэн ба дуут дохио, гэрэлтүүлгээр бүрэн тоноглогдсон, тоормос нь бүрэн ажиллагаатай байх шаардлагатай.
- Ил уурхайн замын хөдөлгөөнийг зохицуулахад "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай" Монгол улсын хуулийн дагуу нэг загварын баталгаат дохио тэмдгүүдийг хэрэглэнэ. Гадны байгууллагаас ирж буй автомашин, трактор болон өөрөө явагч, ачих, өргөх, тээх, зөөх зориулалттай машины жолооч, машинч нарт үйлдвэрийн захиргаанаас авто аж ахуйн захиргаатай хамтран уурхайд ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, уурхайн доторх авто замын сүлжээг танилцуулан, эрх олгосон нөхцөлд ил уурхайд түр ажиллахыг зөвшөөрнө.
- Ил уурхайн замд технологийн зориулалттай автомашинууд нь үйлдвэрийн захиргаанаас тогтоосон хөдөлгөөний хурдыг зөрчин гүйцэж түрүүлэхийг хориглоно. Өөр өөр хурдтай автомашинууд ажиллаж буй үед авто тээврийн байцаагчийн зөвшөөрлийг үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах арга хэмжээ авсан нөхцөлд гүйцэж түрүүлэхийг зөвшөөрч болно.
- Экскаватораар авто тээврийн хэрэгсэлд ачилт хийх үед дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - ачилтад орохоор хүлээж буй автомашин нь экскаваторын утгуурын үйлчлэх хүрээнээс гадна зогсох бөгөөд зөвхөн экскаваторын машинчийн өгсөн дохиогоор ачилтад орох;
  - ачуулж буй автосамосвал нь тоормосолсон байх;

- 3) автосамосвалын тэвшинд ачааг зөвхөн хажуу ба ар талаас нь ачна. Автосамосвалын урдаас ачилт хийх буюу түүний бүхээгийн дээгүүр экскаваторын утгуур давуулж өнгөрүүлэхгүй байх;
  - 4) ачиж буй автосамосвал нь экскаваторын машинчид харагдахуйц газар байрлах;
  - 5) ачилт дууссан нөхцөлд экскаваторын машинчийн өгсөн дохиогоор хөдөлж явах;
  - 6) ачилт хийж байхад автосамосвалын ойролцоо буюу түүний шат тавцан дээр хүн зогсох, бүхээгээс буух, бүхээгт суухыг хориглоно.
5. Автосамосвалын бүхээг нь ачаа ачиж буй үед жолоочийн аюулгүй байдлыг хангах үүднээс дээгүүрээ зориулалтын хамгаалах саравчтай байна. Бүхээг нь зориулалтын хамгаалах саравчгүй автосамосвалд экскаватораар ачаа ачих үед жолооч нь бүхээгээс бууж экскаваторын үйлчлэх хүрээнээс холдсон байна.
6. Ил уурхайд автосамосвал ажиллах үед хориглох зүйлс:
- 1) тэвшийг бүрэн буулгахгүй явах;
  - 2) ачилт хийх газар руу 30 м-ээс илүү зайд (траншей нэвтрэхээс бусад үед) ухарч ойртох
  - 3) цахилгаан дамжуулах шугамын дор тэвш өргөх, засвар хийх;
  - 4) үйлдвэрийн захиргаанаас баталсан технологийн зориулалттай автосамосвалд сууж явах эрх бүхий хяналтын албаны болон зарим нэр зааснаас бусад хүмүүсийг тээвэрлэх;
  - 5) хэвгий, налуу газар автосамосвал тавих, хэрвээ техникийн гэмтлээс болж автосамосвалыг тавих шаардлага гарсан үед жолооч нь өөрөө хөдөлж өнхрөхөөс болгоомжлон хөдөлгүүрийг унтраах, тоормосыг найдвартай бариулах, дугуй дор нь ивээс тавих зэрэг шаардлагатай арга хэмжээ авах;
  - 6) Ил уурхайн технологийн замаас өөр замаар зорчихгүй байх
  - 7) ажил удирдагч ээлжийн ахлагч нараас зааж өгсөн газраас бусад газар ачаа буулгах;
  - 8) автосамосвалыг хэвгий газар руу өнхрүүлж асаах.
  - 9) 25 тн даацтай автосамосвалууд нь тэдгээрийг ухрах үед дуут дохио тасралтгүй өгөх зориулалттай, бүрэн бүтэн төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
7. Ил уурхайд автосамосвалаар ажилтнуудыг зөөвөрлөхдөө үйлдвэрийн захиргаанаас баталсан замын чиглэл, хөдөлгөөний хурд, ажиллах цагийн дагуу зөвхөн автобус буюу хүн зөөвөрлөх зорилгоор тусгайлан тоногдсон автосамосвал хэрэглэхийг зөвшөөрнө. Хүн буулгах, суулгах талбай нь заавал тэгш байна. Авто замын зорчих хэсгийг хүн буулгах, суулгах талбай болгон ашиглахыг хориглоно.
8. Ачих ба буулгах хэсэг нь тээврийн хэрэгсэл(автомашин, чиргүүл)-ийн сэлгээ хийх

чөлөөтэй зай, талбайтай байвал зохино. Эдгээр ачих ба буулгах хэсгийн талбай нь тэгш буюу 0.01-ээс ихгүй хэвгий байж болно. Ачаа буулгах талбайн автосамосвал ухарч буй хэсэг нь тэдгээрийг хэт ухрахаас сэргийлсэн, 25 тн хүртэл даацтай автосамосвалын хувьд 1 м-ээс багагүй өндөртэй хамгаалах далан буюу хашлагатай байна. Ийм хамгаалах далан, хашлага байхгүй талбайн ирмэгт 25 тн даацтай автосамосвал 5 м-ээс дотогш ойртож ухрахыг хориглоно. Автосамосвал ачилт хийх үед хориглох зүйлс:

- 1) хэт том овор хэмжээтэй зүйлс ачих;
  - 2) даацаас нь хэтрүүлэн ачих;
  - 3) ачааг нэг талд нь буюу хазгай ачих.
9. Автосамосвалыг засвар, үйлчилгээ хийхээр зогсоохдоо ачааг бүрэн буулгасан, шавар, цасыг арилгасан байхаас гадна засварын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийг баримтална.
10. Засвар үйлчилгээ хийх, шатахуун авах үедээ автосамосвалыг унтраасан байна.

Эвдэрсэн автосамосвалыг замын зорчих хэсэгт орхихыг хориглоно. Зөвхөн замын хөдөлгөөний дүрэмд заасан анхааруулах тэмдгийг хоёр талд нь (хойд, урд) байрлуулан түр үлдээж болно.

#### **6.4. БАЯЖУУЛАХ ХЭСГИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

1. Хүлээн авах бункерийн талбай дахь ажилтан, анхдагч бутлуурын талбай дахь ажилтнууд нь харилцаа холбооны хэрэгслээр холбогдсон байна.
2. Хүлээн авах бункерт машин тулж зогсохоос хамгаалсан саад тавьсан байна. Өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл хүдрээ бүрэн асгаж, тэвшээ буулгасны дараа хөдөлнө.
3. Хүдэр хүлээн авах төхөөрөмжийн хүдэр буулгах талаас бусад тал нь бат бэх хашлагатай байна. Харин хоёр тийш буулгадаг бол хоёр хажууг нь хашсан байна.
4. Хүлээн авах бункерийн талбай нь тоос сайн дарах хэрэгслээр тоноглогдсон байна.
5. Бункерт гацсан хүдрийг сэтлэх ажлыг тусгайлан гаргасан нүхээр гүйцэтгэнэ. Гацсан хүдэр нураахаар бункерт хүн орохыг хориглоно. Хүдэр бункерт бөглөрөх, гацсан байдлыг арилгахын тулд тусгай (цахилгаан доргилуур, хийн шахуурт төхөөрөмж ба бусад) хэрэгсэл хэрэглэнэ. Бункерт энэ зорилгоор хүн оруулахыг хориглоно.
6. Бункер ба хүлээн авах байгууламжид үзлэг засвар хийхийн өмнө шаардлагатай бол хүдрийг суллаж, битүү бол агааржуулсан байна.
7. Бункер буюу хүлээн авах байгууламжид засварын ажлыг гүйцэтгэхдээ ажлыг хийх наряд-зөвшөөрөл авах ба ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулж дараах нөхцөлийг заавал баримтална. Үүнд:
  - шаардлагатай бол бункерыг хүдрээс бүрэн цэвэрлэсэн байна.

- уг ажил нь байнгын хяналт дор гүйцэтгэгдэнэ.
  - хүлээн авах ба завсрын бункерийн тээвэрлэх байгууламжийн ажлын талбай болон бункерийн түгжих механизмын дэргэд ажил хийж байгааг мэдэгдэх анхааруулах тэмдэг тавьсан байна.
  - бункерт ажилтан орохоос өмнө хүдэр хүлээн авах ба өгөх, тэжээлийг зогсоож тусгаарлалтын журмын дагуу холбогдох арга хэмжээг авна.
  - бункерт ажиллаж байгаа баг нь 3-аас доошгүй хүнтэй байх бөгөөд тэдний 2 нь бункерийн дээд хэсэгт хамт ажиллаж байх ёстой.
  - засварын ажил гүйцэтгэж байгаа ажилтан нь хамгаалах бүс бүсэлж бат бэх бэхлэгээний цэгээс холбосон байна. Татлага нь ажлын үед хүлхийхгүй байх ёстой. Хамгаалах бүснийхээ татлага, конвейерын их бие болон бусад тоног төхөөрөмжөөс уяхыг хориглоно.
  - бункерт ажиллаж байгаа ажилтанд ямар нэгэн аюул тохиолдохоор бол аль болох түргэн гаргана.
  - бункер дотор 12 в-оос дээшгүй хүчдэлтэй зөөврийн гэрлийг хэрэглэнэ.
8. Бутлуурын ажилтан бутлалтаас үүсэх хүдрийн хэлтэрхийд өртөхөөргүйгээр хамгаалагдсан байна.
9. Бутлуурт хүдрийн том хэсэг тээглэх, гацах үед түүнийг өргөх хэрэгслийн тусламжтайгаар зайлуулах эсвэл «тэсэлсэн блокоос том овор хэтэрсэн хүдэр ачихгүй байх, газар дээр нь буталж жижиглэн ачих»
10. Бутлуурт гацсан хүдрийн аюулгүй ажиллагааны шаардлага бүрэн хангаагүй тохиолдолд гараар авах, алх, лантуугаар бутлахыг хориглоно.
11. Бутлуурын ажлын хөндийд орж ажиллахдаа хамгаалах бүс хэрэглэх ба дээрээс биет унахаас сэргийлэх арга хэмжээг авна.
12. Бутлуурт орсон төмрийг огтлохдоо зөвшөөрөл-нарядын дагуу удирдах ажилтны хяналтын дор гүйцэтгэнэ.
13. Бутлуур хүдэрт дарагдан аваарын байдалд зогссон нөхцөлд эрсдэлийг үнэлж, төлөвлөгөө боловсруулж эрх бүхий албан тушаалтны зааврын дагуу бутлуурыг хоослох, цэвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.
14. Чичиргээт шигшүүрийг суурилуулсан барилга, байгууламж нь шигшүүрийг ажиллуулах үед гарах доргилтыг даах чадвартай байхаар тооцоолон хийгдэнэ.
15. Шигшүүр нь шигшигдэж буй материал шидэгдэж гарахаас хамгаалсан хийц, хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна.
16. Хүдрийн хэлтэрхий үсрэхээс сэргийлж бутлуурт хүдэр өгөх амсарт:
- а. конусан бутлуурыг авагддаг битүү төмөр хаалтаар халхална.



б. хацарт бутлуураас хүдрийн хэсэг үсрэхэд, саад хийсэн 1 м-ээс доошгүй өндөртэй саравчтай цулгүй тал бүрхүүлтэй байна.

#### **6.5. ТЭСЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ҮЕД БАРИМТЛАХ ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ**

Уурхайд хийгдэх тэсэлгээ бүрт өрөмдлөг тэсэлгээний ажлын паспорт боловсруулж мөрдлөг болгоно. Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм, тухайн уурхайд хийгдэх мөрдлөг журмын заалтуудыг хатуу баримталж тэсэлгээний ажлыг зохион байгуулна.

- ✓ *Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг зарцуулах зөвшөөрөл авах*
- ✓ *Тэсэлгээний материалыг агуулахаас зөөж тэсэлгээний блок, мөргөцгүүдэд хүргэх*
- ✓ *Цооног, шпур цэнэглэх ба түгжээс хийх*
- ✓ *Тэсрэлтийн аюултай бүсээс хүмүүс болон тоног төхөөрөмжийг гаргах*
- ✓ *Тэсэлгээний схемийн холболтуудыг хийж тэсэлгээнд бэлтгэх*
- ✓ *Цахилгааны шугамуудыг шалгаж холболт хийх ба ачигч машин зэрэг төхөөрөмжүүдийг мөргөцгүүдэд байршуулж ажилд бэлдэх. Зам тээврийн холбогдолтой малталтуудын сэргээлтийн ажлуудыг хийх*
- ✓ *Тэслэгдсэн чулуулгийн холбогдолтой хяналтын хэмжилт, тооцоог хийж дүгнэлт гарган тухайн тэсэлгээний ажлыг дуусгасан тухай баримт бичгийг бүрдүүлэх*

ХАБЭА-н менежментийн хөтөлбөрийг хөдөлмөрийн аюулгүй байдал, хөдөлмөрийн тухай эрүүл ахуй, галын аюулгүй байдал, гамшигаас хамгаалах тухай, нийгмийн даатгалын тухай гэх мэт хуулиуд болон ХАБЭА-н норм стандартуудыг баримтлан боловсруулж хэрэгжүүлнэ.

## 7. БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 7.1. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

#### 7.1.1. Байгаль орчныг хамгаалах ажлын удирдлага ба хяналтын систем

Байгаль орчны мэргэжилтэн удирдлагатай хамтран байгаль орчныг хамгаалах ажлыг зохион байгуулах, учирч болзошгүй хор хөнөөлийг урьдчилан төлөвлөж байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, хүрээлэн буй орчны бохирдол, доройтолтой холбогдох хууль тогтоомж, шийдвэр, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

